

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-35
<hr/>	
1.Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцах	5-24
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	24-25
3.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай/	25-26
4.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандаж “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай” тавьсан асуултын хариуг сонсох	26-35

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 18-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 12 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Н.Учрал.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа оролцов.

Нэг.Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар, мөн хорооны гишүүн Д.Ариунтуяа, Д.Мягмарцэрэн, С.Энхтөр, Ажлын албаны дарга Д.Мөнхзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Б.Галсанбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлангийн талаар Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Х.Нямбаатар, Д.Цогтбаатар, Ц.Сандаг-Очир, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар, мөн хорооны гишүүн Д.Мягмарцэрэн, Д.Ариунтуяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ш.Адъяаа, Ц.Сандаг-Очир, Б.Пүрэвдорж, Байнгын хорооны дарга Б.Энхбаяр нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцав.

Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Энхбаяр: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Хууль зүйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын саналыг гаргав.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Энхбаяр: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дөрөв. Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандаж “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай” тавьсан асуултын хариуг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний Эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын Шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Н.Жамьянхүү, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор, Хууль цаазын Шадар зөвлөх Б.Баярхүү, Хүний Эрхийн Үндэсний комиссын референт Г.Ганбат, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Ганзориг, Мөрдөн байцаах албаны дарга Б.Батсуурь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат байлцав.

Асуултын хариуг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Асуултын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Цогтбаатар, С.Одонтуяа нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Мөрдөн байцаах албаны дарга Б.Батсуурь, Хүний Эрхийн Үндэсний комиссын гишүүн Б.Энхболд, Байнгын хорооны дарга Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагаас Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандаж “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай” тавьсан асуултын хариуг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 11 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр,
 Мягмар гараг
 Төрийн ордон “Жанжин
 Д.Сүхбаатар” танхим
 11 цаг 12 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
 ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР
 /МЯГМАР ГАРАГ/-ИЙН
 ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
 ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энхбаяр: Байнгын хорооны эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулъя. Энхбаяр ирсэн, Адъяаа ирсэн, Алтанхуяг гишүүн чөлөөтэй. Бат-Амгалан гишүүн ирсэн. Бямбацогт, Нямбаатар, Сүхбаатар, Учрал нарын гишүүд өнөөдөр Улаанбаатар хотын Түгжрэлийн үндэсний хороо хуралдаж байгаа юм байна. Тэгээд энэ асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүд хуралдаан давхцаж байгаа юм байна. Ганбат гишүүн орон нутагт, Дэлгэрсайхан гишүүн орон нутагт, Мөнхбаатар дарга чөлөөтэй, Мөнх-Оргил гишүүн ирсэн, Ц.Мөнхцэцэг гишүүн чөлөөтэй, Пүрэвдорж гишүүн ирсэн, Раднаасэд гишүүн ирсэн, Сандаг-Очир гишүүн ирсэн, Сэргэлэн гишүүн ирсэн, Цогтбаатар гишүүн ирсэн, Б.Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцах,

2. “Монгол УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард ХЗБХ-ны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл,

3. “Байнгын хорооны тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл,

4-т, УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга Одонтуяагаас ХЗДХ-ийн сайдад хандаж Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай тавьсан асуултын хариуг сонсох гэсэн ийм 4 асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Шүүхийн сахилгын хорооноос 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 0190 дугаар албан бичгээр УИХ-д ирүүлсэн Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцана.

Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайланг Шүүхийн сахилгын хорооны дарга Хашигамбайн Хашибаатар танилцуулна. 4 номерын микрофон.

Х.Хашибаатар: ХЗБХ-ны дарга болон УИХ-ын гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэнд Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны танилцуулгыг бас ийм товч хэлбэрээр тайлангаар, биечлэн УИХ-ын бүх гишүүдэд хүргүүлсэн байгаа. Тийм учраас тайлантай холбоотой бас 1 товчхон танилцуулгыг хийе.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116-гийн 3 дахь хэсэгт Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд багтаан УИХ-д хүргэж байхаар заасан. Үүний дагуу Сахилгын хорооны

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

2022 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанар, үр нөлөөг сайжруулах, шүүгчийн ёс, зүй сахилгын зөрчил, түүнд тохирох хариуцлагыг шударгаар оногдуулах зарчмыг барьж энэ хугацаанд бид нар ажиллалаа.

Шүүхийн сахилгын хорооны 2022 онд хийж гүйцэтгэсэн зарим онцлог ажлыг бас дурдвал Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг мэргэшүүлэх тал дээр бид нар нэлээн анхаарч бас ажиллалаа. Мөн шинэ тутам байгууллага учраас үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм, журмуудыг Монгол Улсын шүүхийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж батлуулсан.

Төрийн захиргааны алба хаагчдыг бас мэргэжүүлэх багц сургалтад хамрагдуулах ажлыг бид бас ажлын албаа чадавхжуулах хүрээнд энэ ажлыг бас зохион байгууллаа. Мөн төрийн захиргааны шинэ байгууллага учраас төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-өөр бас батлуулж ажиллуулсан.

Олон нийтэд өөрсдийн хийж буй үйл ажиллагаа болон шүүгчид хариуцлага тооцсон шийдвэрийг ил тод байлгах үүднээс бас бид нар цахим хаягийг ажиллуулж, фэйсбүүк болон твиттер, өөрийн сайтаараа бол гаргасан шийдвэрүүдийг бол тогтмол оруулж танилцуулж байгаа. Энд бол иргэд бол нэлээн нээлттэй бас орж байгаа.

Мөн олон улсын бусад ижил төсөөтэй байгууллагуудтай бас тэдгээрийн туршилагыг судлах, харилцаа холбоотой хамтран ажиллах чиглэлээр бас нэлээдгүй ажлыг зохион байгууллаа.

Энэ хугацаанд хүлээж авсан нийт өргөдөл гомдлыг 96.5%-тай шийдвэрлэж ажилласан байна.

Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын алба бол ажилладаг. Энэ ажлын алба маань Захиргааны удирдлагын хэлтэс, Хууль зүйн хэлтэс, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтэс гэсэн 3 хэлтэстэй. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт 26 албан хаагчдаар энэ хугацаанд чиг үүргээ гүйцэтгэж ажиллаж ирлээ. Тус ажлын албаны хүний нөөц бүрдүүлэх, тэдгээрийг чадавхжуулах, мэргэшүүлэх, ур чадвар, багаар ажиллах чадамжийг дээшлүүлэх, төлөвшүүлэхэд анхаарч хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарч бас ажиллалаа.

2022 онд тус байгууллагын төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 3 тэрбум 528.9 сая төгрөгөөр батлагдсан. Гүйцэтгэлээр бол 3 тэрбум 413.9 сая төгрөгийг зарцуулж, төсвийг 115 сая төгрөгөөр буюу 3.3%-аар хэмнэж, төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулсан. Улмаар бол төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын хэрэгцээнд шаардагдах бараа материал, тавилга, программ хангамж, автомашин, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг бол хуулийн хугацаанд зохион байгуулж ажилласан байна.

Түүнчлэн гадаад орнуудын адил чиг үүрэг бүхий байгууллагуудын олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоон бэхжүүлж, хөгжүүлэх чиглэлээр ажиллаж бас энэ чиглэлээр ажилласан. Энэ хүрээнд АНУ-ын муж улсуудын Шүүхийн үндэсний төв, Канад Улсын Холбооны Шүүхийн комиссарын алба, Канад Улсаас Монгол Улсад суух ЭСЯ, Европын Холбооноос Монгол Улсад суугаа төлөөлөгчийн газар, олон улсын эрх зүйн

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хөгжлийн байгууллага, Нээлттэй нийгэм зэрэг байгууллагуудтай бол уулзалт, семинар зохион байгуулж, хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн. Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааг болон шүүгчдийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, өргөдөл, мэдээллийн шийдвэрлэлт, сахилгын хорооны хуралдааны шийдвэрийн талаар бол ил тод, нээлттэй, хурдан шуурхай, үнэн зөв мэдээ мэдээллийг байгууллагын албан ёсны сайт Judiscom гэдэг цахим сайтаар бол бид нар байнга мэдээлж байгаа. Энэ талаар бол товчилсон мэдээллийг бол фэйсбүүк, твиттер, бусад цахим хэрэгслийг бид ашиглаж мэдээллээ түгээж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн сахилгын хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд шүүгчийн сахилга, хариуцлагыг асуудлаарх өргөдөл, гомдол, мэдээлэл, эсэргүүцэл, хэрэг маргааныг дангаар болон хамтын зарчмаар хянан хэлэлцээд олонхын саналаар шийдвэрлэдэг. 2021 оны үлдэгдэл 151 өргөдөл мэдээлэл, тайлант хугацаанд буюу 2022 онд 311 өргөдөл мэдээлэл хүлээж авсан. Ингээд нийт бол 462 өргөдөл мэдээллийг шийдвэрлэжээ. 21 оны үлдэгдэл гэдэг маань Шүүхийн сахилгын хороо 21 оны 11 сарын 18-ны өдөр УИХ-аас шүүгч бус 5 гишүүн томилогдсоноороо бүрэн бүрэлдэхүүн бүрдэж, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойших хугацааны энэ тоо байгаа. Өмнө нь бол бас Шүүхийн ёс зүйн хороо буюу өмнөх байгууллага маань бас бүрэлдэхүүн бүрдээгүйтэй холбоотой өргөдөл гомдол бас нэлээдгүй хураагдсан байсан. Энэ өргөдөл гомдлын үлдэгдэл гэж ойлгож бас болно.

Дээрх хүлээн авсан 462 өргөдлөөс энэ 2 оны өргөдөл нэмэгдсэн гэсэн санаа. Мэдээллийг бол 201-ийг нь сахилгын хэрэг үүсгээд, 245-д нь бол сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан. Үлдэгдэл 16 өргөдөлтэй он дамжиж ажилласан байна. Тус хороонд иргэдээс ирүүлж

байгаа өргөдөл мэдээллийг агуулгаар нь авч үзвэл ирүүлсэн өргөдөл мэдээллийн 346 буюу 75% нь хориглосон, 106 буюу 20.4% нь үүрэг болгосон, 10% буюу 4.6 нь хязгаарласан зохицуулалтыг зөрчсөн гэх агуулга бүхий өргөдөл мэдээллүүд ирүүлсэн байна. Энэ өргөдөл мэдээллийн ирүүлсэн түүвэр болон ангиллыг бол та бүхэнд бас энэ хүргүүлсэн тайлан дотор нарийвчлан харуулсан байгаа. /Нямцогт дарга энэ өргөдөл мэдээллийн хуваарилалтыг бас харуулчхаарай/

Тус хороонд иргэдээс ирүүлж байгаа өргөдөл мэдээллийг агуулгаар нь авч үзвэл Монгол Улсын, түүнчлэн өргөдөл мэдээллийн шүүхийн харьяаллаар нь авч үзэхэд орон нутгийн 117, нийслэл болон дүүргийнх 147, давж заалдах шатны 35, хяналтын шатын 26 шүүгч нар нэр холбогдож байгаа юм. Энэ бол давхардсан тоогоор бас байгаа гэдгийг бас ойлгож үзэх хэрэгтэй.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 113 дугаар зүйлд Шүүхийн сахилгын хорооны хуралдааны шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан эсэргүүцэл гомдлыг тус хорооны хянан үзэх хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр заасан. Үүний дагуу тус онд Шүүхийн сахилгын хорооны магадлалд илтгэгч гишүүнээс 1 эсэргүүцэл, сахилгын хэргийн оролцогчоос 15 гомдол гаргасныг хянан хэлэлцсэн. 9 гомдол, 1 эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож Шүүхийн сахилгын хорооны магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэн хяналтын тогтоолыг гаргасан байна.

Тайлант хугацаанд шинээр сахилгын хэрэг үүсгэсэн 201, гомдол шийдвэрлэх хуралдаанаар сахилгын хэрэг үүсгэсэн 29, өмнөх оны үлдэгдэл сахилгын хэрэг 72, сахилгын хэргээс тусгаарлаж шинээр үүсгэсэн 8, нийт 310 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж шийдвэрлэжээ. Шүүхийн сахилгын хорооноос нийт 40 шүүгчид энэ 2021 оны бас тоо нэмэгдсэн байгаа. Давхардсан тоогоор сахилгын шийтгэл оногдуулсны

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хаалттай сануулах 3, нээлттэй сануулах 14, цалингийн хэмжээг 6 хүртэл сараар 20 хүртэл бууруулах нь 17, шүүгчийн бүрэн эрхийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж сургалтад суулгахыг даалгах 1, огцруулсан 5 шүүгч байна. Үүнээс шийдвэр нь хүчин төгөлдөр болсон одоогоор 27 шүүгчид сахилгын шийтгэл хүчин төгөлдөр болоод байна. Үлдэгдэл нь бол бас гомдол гаргаад өөр хяналтын шатанд явж байна гэж бас ойлгож болох нь ээ.

Шүүхийн сахилгын хороо нь шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэл, олон нийтийн итгэлийг хүлээх талаар идэвх чармайлт гаргаж ажиллалаа. Шүүгчийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлж, тэдний сахилгын зөрчлийг хөндлөнгийн нөлөөнөөс ангидар шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж оногдуулах хариуцлага шийтгэлийг бодитой болгох, шүүх засаглалын нийтлэг сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажилласнаар сахилгын хорооны үйл ажиллагаа ер нь жигдэрч ажиллаж байна.

Түүнчлэн хөдөө орон нутагт ажиллахад найдвартай, туулах чадвартай автомашинтай болох, материаллаг байдлыг бэхжүүлэх, улмаар ололт амжилтаа бататгах, гишүүдийн хараат бус үйл ажиллагаа явуулах боломжоор хангах зорилгоор ажлын албаны ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулахад анхаарлаа хандуулж, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд зарим материаллаг асуудлыг шийдвэрлэж чадсан.

Цаашид байгууллагын стратеги төлөвлөгөө болон хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, стратеги төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх нь Шүүхийн сахилгын хорооны ил тод, нээлттэй, иргэдийн дэмжлэгтэй, бие даасан байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай юм. Мөн байгууллагын үйл

ажиллагааг цахимжуулах, цахим шилжилтийн ажлын хүрээнд цахим гарын үсэг ашиглах болон иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, гомдлыг хүлээн авч бүртгэх, сахилгын хэргийн бүртгэл, хяналтын системийг нэвтрүүлнэ. Уг системд нэвтэрснээрээ тайлан, мэдээ хурдан шуурхай гарах, сахилгын хэрэг, өргөдөл мэдээлэл, гомдол, эсэргүүцэл, санал, хүсэлтийг шийдвэрлэх, даргалагч бүрэлдэхүүн, илтгэгч гишүүнийг томилох ажиллагааг системээс тойрог дотор санамсаргүй тохиолдлоор цахимаар хуваарилж, гишүүдийн ачааллыг тэнцвэржүүлнэ. Энэ 2022 оны 12 сарын 31-ний байдлаарх танилцуулга. Одоо бол бид энэ цахим хөгжүүлэлтээ хийгээд 03 сарын 03-наас бол хэрэгжүүлж эхлээд байгаа гэдгийг бас энд илэрхийлэх талтай байна.

Иймээс юуны өмнө Шүүхийн сахилгын хорооны хараат бус байдал, бие даасан байдал, материаллаг хангамжийг бэхжүүлэх хүрээнд өөрийн ажлын албан байртай болох явдал хамгийн чухлаар тулгамдаж байгаа асуудал бөгөөд энэ талаар бас санаачилгатай ажиллаж асуудлыг шийдвэрлэх болно. Мөн хэдийгээр улс эх орны санхүү, эдийн засгийн байдал амаргүй байгаа боловч Шүүхийн сахилгын хорооны бие даасан, хараат бусаар ажиллахад, шинэ тутам байгууллагад бол энэ төрийн хэмнэлтийн тухай хууль энэ шинэ байгууллагад их хүндрэлтэй байгааг бас харгалзаж үзэж, өгөхийг та бүхнээс хүсье. Танилцуулж дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Тайланг ингээд дэлгэрэнгүй хүргэсэн учраас би товч танилцуулсан байна. Тэгээд асуултад хариулъя.

Б.Энхбаяр: Шүүхийн сахилгын хороо бол Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллага болсон. Тэр утгаараа бол тайлан хэлэлцэж, ямар нэгэн шийдвэр гарахгүй, тайлантай танилцаж байгаа гэдгийг гишүүдэд хэлье.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Энэ тайлантай танилцах хуралдаанд дараах албан тушаалтнууд оролцож байна. Нэгдүгээрт, Хашибаатар Шүүхийн сахилгын хорооны дарга, Ариунтуяа Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Мягмарцэрэн Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Энхтөр Шүүхийн сахилгын хорооны гишүүн, Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны дарга гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Шүүхийн сахилгын хорооны тайлантай холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

Б.Энх-Амгалан: Би нэг 2 тодорхой асуулт асууя. Энэ шүүх бол иргэдэд нээлттэй, ил тод, шударга, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, аливаа нөлөөллөөс ангид байх ийм чиг хандлагыг бол Шүүхийн сахилгын хороо анхаарлаа хандуулж ажиллах ийм ёстой. Тэгээд сүүлийн үед ингээд мөрдөгч байгууллагууд гарч ирээд ингээд нийгэмд зарлачихдаг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр. Хэрэг бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд байж байгаа юмнууддаа энэ бол гэмт хэрэгтэн гээд зарлачихдаг, тэгээд нийгмээр яллуулдаг. Тэгээд нийгэм тэр хүнийг хараад зүхээд, яллаад хэн ч биш болгосон хойно нь тэгээд 1 алгын чинээ цаас өгдөг, буруугүй юм байна гэж. Ингэж болох юм уу? Энэ дээр энэ Одонтуяа гишүүний 1 асуулт юун дээр байна. 2020 онд баривчлах ажиллагааны 99.3%, 2021 онд 98.3% нь шүүхийн шийдвэргүйгээр хийгдсэн гээд. Тэгээд энд нөгөө шүүх маань хараат бус байж чадаж байна уу? Энэ ажиллагаа ингээд цаашидаа ингээд давтагдаад яваад байх уу? Энэ нөгөө Үндсэн хуулиар хэрвээ хүн шүүхийн шийдвэрээ шийдвэр одоо шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна, шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй бол хэнийг ч гэм буруутайд тооцож үл болно гэдэг энэ Үндсэн хуулийн чинь зарчим алдагдаад байна шүү дээ. Үүнийг

цаашид ер нь яах вэ? Та бүхэн маань 1 саналаа хэлээч.

Бид нар тэгээд явж байгаад энэ нийгмийн эрэлт хэрэгцээ, иргэд, олон нийтээс хүсээж байгаа шударга ёсны хүсэмжлэл, сахилга хариуцлага, ёс суртахуун, ард түмний нийтлэг эрх ашигт нийцүүлэн шийдвэр гаргана гээд. Тэгээд нөгөө хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиалаар явж байгаа мэдээндээ хөтлөгдөөд шүүх нөлөөнд автах ийм аюултай байна шүү дээ. Нийгмээрээ давлагаалчихсан юм чинь одоо энэ дээр 1 шийдвэр гаргахгүй бол болохгүй. Аягүй бол нөгөө шүүгч нь энд урвачихсан, хахууль авчихсан, эсвэл нөлөөлд автчихсан гэж хэлнэ. Тийм учраас 1 юм өгөхөөс гээд алх цохичихдог байж болохгүй биз дээ. Ийм нөхцөл байдлыг та бүхэн маань юу гэж бодож байна. Нийгмийн нийгмийн шударга ёсыг хангахын тулд ингэнэ гээд яриад байдаг энэ юмыг та бүхэн маань энэ хууль зүйн талаасаа яг юу гэж бодож байна? Үүнийг 1 хариулаач, 1 дэх нь.

2 дахь нь, их олон жил 1 дорoo ажиллаж байгаа шүүгч нарыг сэлгэн ажиллуулахгүй юу? Одоо хөдөө орон нутагт бол ингээд 20, 30 жил ажиллачихдаг, тэгээд тэндээ бүр ингээд бүгдийг нь таньдаг болчихсон. Тэгээд нөлөөлд автах байдал маань бас нэлээн их ийм байдалтай юмнууд байна л даа. Тэгэхээр үүнийг бас сэлгэн ажиллуулах ийм бодлого барьж байгаа юу? Энэ дээр ямар санаа оноотой байна? 1 ийм 2 асуултад маш тодорхой хариулаад өгөөч.

Б.Энхбаяр: Энх-Амгалан гишүүний асуултад ШЕЗ уг нь хариулах асуулт асуусан. Тийм учраас яг бас энэ дээр өөрсдийн эрхлэх асуудлын хүрээтэй холбоотой асуудал дээрээ бас хариулах байх. Нөгөө шүүгчдийг сэлгээж ажиллуулах, шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахтай холбоотой асуудал бол ШЕЗ-ийн чиг үүрэгт байгаа. Өнөөдөр бол бид бол Шүүхийн сахилгын хорооны

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тайланг сонсож байгаа. Хашибаатар дарга хариулах уу? 4 номерын микрофон.

Х.Хашибаатар: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Сая ХЗБХ-ны дарга хэлчихлээ. Сэлгэн ажиллуулах болон хараат бус байдлыг бол ШЕЗ хариуцахаар хуульд тусгасан байгаа. Шүүгч хараат бусаар ажил гүйцэтгэх бас 1 эсрэг талынх нь тэнцвэр бол бас сахилга хариуцлага явж байдаг. Бид бол Шүүхийн сахилгын хороо, шүүгчийн сахилга, хариуцлагатай холбоотой үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгдөг, шалгадаг, энэ чиглэлийн үйл ажиллагаа дээрээ чиглэж ажилладаг гэдгийг бас тодотгож хэлэх нь зүйтэй байх. ШЕЗ-өөс бас энэ дээр дэлгэрэнгүй бас хариулт өгөх байх.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн асуултаа асууя. Нямбаатар гишүүн асуулт асууя. Уучлаарай.

Х.Нямбаатар: Баярлалаа. Тийм, 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бас 1 том хэсэг бол шүүх эрх мэдлийн хяналт тэнцвэрийг хангах зорилгоор хуульчдаас шүүгчийг сонгон шалгаруулдаг байгууллагыг нь ШЕЗ, шүүгчдэд хариуцлага хүлээлгэдэг хариуцлага тооцдог, чөлөөлдөг байгууллага нь Шүүхийн сахилгын хороо байхаар ингээд Үндсэн хуульд хуульчилж өгсөн. Тэгээд өнөөдөр бас Үндсэн хуулийн байгууллагын хувьд УИХ-д асуудлаа танилцуулж байна. Би тэгээд Хашиаа даргаас асууя даа.

Бид нар энэ хуулийг хэрэгжүүлээд Шүүхийн тухай хууль хэрэгжиж эхлээд бас тодорхой хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд 1 зүйл ажиглагдаад байгаа нь шүүгчийн сахилгатай холбоотой, ёс зүйтэй холбоотой асуудал дээр бид нар шүүхийн тухай хуульд заасан тэр үндэслэл журмын дагуу хариуцлага хүлээлгэх асуудлууд яригдаж байна. Тэгвэл цаашид шүүгчдийн мэргэжлийн алдааг бид нар ер нь яах ёстой юм. Өөрөөр хэлбэл танай байгууллага дээр энэ

хуулийнхаа хэрэгжүүлэх явцад дүгнэлт хийж, цаашид Шүүхийн тухай хуульд шүүгчийн мэргэжлийн алдаа гаргасан илтэд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг зарим анхан шатын шүүхээс гэм буруугүйд тооцоод цагаатгаад шийдвэрлэсэн тохиолдлууд саявтархан хүртэл гарч байна л даа. Үүнийг цаашид яамаар байна? Бид нар үүнийг мэргэжлийн байгууллагуудынхаа саналыг сонсож байж мэргэжлийн Байнгын хороон дээр үүнийг бас ярьж байж, цаашид хууль зүйн бодлогын хувьд бид нар бас эргэж харах шаардлагууд байна. Шүүхийн тухай хууль бид нар бол өнгөрсөн 14 хоногийн өмнө ШЕЗ, Шүүхийн сахилгын хорооны төлөөлөлтэй уулзаж шүүх байгуулах хууль түүнийг дагасан процессын хуулиуд бусад дагасан хуулиудын талаар ерөнхий санал солилцсон. Энэ дээр бол яг энэ асуудлыг бас төдийлөн ярьж хөндөөгүй байгаа. Тэгэхээр Шүүхийн сахилгын хорооны даргаар 2 дараалж ажилласан 2 дарга ер нь саналаа хэлбэл, Байнгын хорооны гишүүдэд 1 саналаа хэлээч.

Бид нар мэргэжлийн алдаа тэгээд гарахаар нь гарвал гараг ээ, тэгээд дээд шатны шүүх нь зөвтгөх байлгүй дээ гээд сууж байх уу? Энэ дээр 1 саналыг нь сонсох гэсэн юм.

Б.Энхбаяр: 4 номерын микрофон.

Х.Хашибаатар: Нямбаатар гишүүний асуултад хариулъя. 2019 оны шүүхийн шинэчилсэн найруулгын энэ хуулиар бол бас нэлээдгүй үйл ажиллагааг бас зохицуулж өгсөн сайн хууль болсон. Түүний үр дүн бол бас энэ Шүүхийн сахилгын хороог бие даасан байдлаар нь гаргаж, үйл ажиллагааг явуулж байгаа нь бас эндээс бас бид нарын сая танилцуулсан тайлангаас бас харагдах байх.

Шүүгчийн мэргэжлийн хороо гэж хуучин бол байсан. Мөн Шүүгчийн ёс зүйн хороо, Мэргэжлийн хороо гэж 2 хороо байсан. Мэргэжлийн хороо бол шүүгчийн

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ажил мэргэжилтэйгээ холбоотой гаргасан шийдвэрт үнэлэлт, дүгнэлт өгөх бас эрх үүрэгтэй байсан. Одоо бол энэ Шүүхийн тухай хуульд бол энэ зохицуулалт байхгүй, түүний тодорхой хэсгийг бол манайд байгаа. Тухайлбал Шүүхийн тухай 50 дугаар зүйлд заасан 40 хориглолт дотор 3 зүйл заалт энэ чиглэлийн агуулгыг бас агуулдаг. Шүүхийн сахилгын хороо бол шүүхийн гаргасан шийдвэрийн шийдвэрийг бол үнэлэлт, дүгнэлт өгөхгүй, харин түүнд байгаа хуулийн илт тодорхой заасан заалтыг зөрчсөн агуулга бүхий, мөн шүүхийн шийдвэртээ үндэслэл бичээгүй, мөн түүнчлэн шүүхийн шийдвэрт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг дүгнээгүй гэсэн ийм 3 агуулга бүхий мэргэжлийн алдааны агуулга бол энэ зөрчилд бол орж өгсөн байгаа. Ер нь цаашидаа бол шүүгчийн мэргэжлийн алдааны чиглэлээр бас зохицуулж өгөх нь зөв байх. Энэ чиглэлээр бас нарийн зохицуулж өгөхгүй бол шүүгч гаргасан шийдвэрийнхээ төлөө бол хариуцлага хүлээхгүй, үүнийхээ далбаан дор бас хариуцлагагүй үйлдэл, шударга бус үйлдэл гаргах үндэслэл бас бүр өгөх магадлалтай. Тэгэхээр үүнийг бол бас цаашидаа хууль тогтоогч нар мэргэжлийн байгууллагууддаа судалгаа хийж байгаад шийдвэрлэх нь зүйтэй гэж би бол хувь хүнийхээ хувьд бодож байгаа. Ийм алдаа бол ер нь нэлээд байдаг. Одоо энэ өргөдлөөр ингээд харахаар манайд ирж байгаа 400 гаруй өргөдлийн ихэнх өргөдөл нь бол шүүхийн шийдвэртэй холбоотой гомдлууд байдаг. Шийдвэртэй, энэ дээр бол эргээд бас хараад дүгнэлт хийх бас боломжтой. Тэгэхээр цаашидаа бас үүнийг бас засаж сайжруулъя. Шүүхийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулъя гэвэл Сахилгын хороонд бас энэ чиг үүргийг бол өгөхөд бол боломжтой гэж бид нар энэ зүгээс үзэж байгаа юм.

Б.Энхбаяр: 3 номер Мягмарцэрэн дарга.

Д.Мягмарцэрэн: Энэ өдрийн амрыг эрье. Эрхэм гишүүн Нямбаатар гишүүний асуултад хариулъя. Бүтэн 1

жилийн хугацаанд Шүүхийн сахилгын хороог удирдаж ажилласны үр дүнд дараах саналыг хэлж болж байна. Ерөнхийдөө агуулга бол Хашбаатар даргын хэлсэнтэй нийцнэ. Тэгэхдээ тодруулж хэлэхэд Шүүхийн сахилгын хороонд хуулиар бол тодорхой зүйлүүдийн заалтыг өгчихсөн байгаа. Үүнийг хууль тогтоогчид та бүгд шинээр нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульд оруулж өгөх юм бол Шүүхийн сахилгын хороонд бол мэргэжлийн алдааг дүгнэлт гаргах, шалгах асуудлыг бол хариуцуулж болох талыг ажиглагдсан. Яагаад тэгж үзсэн гэхээр иргэд өгсөн өргөдөл гомдол дээр яг ажиглалт хийгээд үзэхээр шийдвэрт гомдсон байдаг. Шийдвэр нь гомдол бол мэдээж 2 талд зэрэг гарахгүй, 1 талд нь сайн үйлчил, нөгөө талд нь гомдоно. Тэгээд юу ажиглагдсан бэ гэхээр анхан шатны шүүх дээр 1 шийдвэр, давж заалдах шатны шүүх дээр 1 шийдвэр, хяналтын шатны шүүх дээр өөр шийдвэр гардаг. Эсвэл яг эсрэгээрээ. Тэгэхээр зүгээр иргэд бол юу гэж хараад байгаа гэхээр эсвэл анхан шатны шүүх нь буруу шийдээд, дээд шатны шүүх нь зөв шийдээд байгаа юм уу, эсвэл анхан шат нь зөв шийдээд, дээд шатны шүүх нь буруу шийдээд байгаа юм уу гэсэн агуулгаар манайд өргөдөл хандаад байгаа.

Шүүхийн хараат бус байдалд халдаж болохгүй, энэ бол хуулиар хориотой. Гэвч тодорхой асуудлууд дээр шалгаж шийдэж, мэргэжлийн дүгнэлт гаргах нь зүй ёсны хэрэг юм байна гэж ажиглагдсан. Үүн дээр би зүгээр тодруулаад хэлэх юм бол 3 шатны шүүхээр явсан, эцэслэгдэн шийдсэн асуудал дээр мэргэжлийн дүгнэлт гаргаад шийдвэрийг нь тэр дээд шатны шүүх нь арга хэмжээгээ тооцдог байж болох юм. Шалгах ажиллагааг нь бол Шүүхийн сахилгын хороо бол шалгаж бололцоотой гэж үзэж байгаа. Хариулт дууслаа.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Цогтбаатар: Баярлалаа. Өнөөдрийн мэндийг хорооны гишүүддээ хүргэе, Байнгын хорооны гишүүддээ. Тэгээд энэ өнөөдөр энэ хэлэлцэж байгаа асуудал чухал асуудал. Тэгээд Шүүхийн сахилгын хорооны хувьд гэвэл би 1 ийм зүйл хэлмээр байгаа юм. Ер нь бол Монгол Улсын шүүх хараат бус байх ёстой. Тэгээд энэ хараат бус байдлын гол баталгаануудынх нь 1 нь сахилга баттай, энэ шүүх тогтолцоо байгаа юм. Өөрөөр хэлбэл шүүхэд сая өөрөө хэлж байна. Энэ сахилгын асуудал яриад шүүхэд нөлөөлөх гээд байгаа гэдэг асуудал биш. Эсрэгээрээ энэ шүүх тогтолцоо өөрөө сахилга бат нь чанга, хуулиа яс барьдаг байхад энэ шүүх өөрөө хараат бус байх баталгаа нь бүрдэж байгаа юм. Ер нь шүүгч хүний хувьд бол нөгөө хараат бус байна гэдэг бол шүүгч хүн юунаас хамаарах ёстой вэ гэхээр ерөөсөө цэвэр шүүгч хүнд дарга байхгүй, шүүгч хүнд хууль, дотоод итгэл үнэмшил ерөөсөө дарга. Тэгэхээр би та бүгдээс асуух асуулт. Энэ ил, далд шүүгчдэд аливаа би сахилга бат ярихаар энд тэнд бусад асуудал яримааргүй байна. 1 гол асуудал. Юун дээр том эрсдэл гараад байгаа вэ гэхээр энэ дарга нарын өрөөнд ил, далд дуудаж үүрэг даалгавар өгөөд, бодлогын нөлөөлөл гаргаад, ийм юм байгаад байхаас урьдчилан сэргийлэх ямар нэгэн бодлого, арга хэмжээ та хэд маань авч байна уу? Би Нямбаатар сайдад дээр 1 нэгдсэн чуулган дээр бүр ийм зузаан материал би өөрөө очиж гардуулж өгч байсан. Гадаадад байгаа Монголын ардчиллын юуг дүгнэж байдаг ардчиллын өнөөдрийн статусыг дүгнэж байдаг гадаадын бүх байгууллагууд, ер нь бүх шүүх. Монголын шүүхийг хараат болчихсон, авлига, хээл хахууль тодорхой хэмжээнд давтагдчихсан гэсэн дүгнэлтүүд бүр жигд гарсан байгаа. Тэгэхээр та нарын үйл ажиллагааны би энэ тайлантай яг холбогдуулаад асуух гэж байгаа юм.

Та нарын үйл ажиллагааны явцад энэ дүгнэлт, энэ үзэл бодлыг өөрчлөх, энэ чиглэлийн үр дүн хэзээ гарах вэ? Яагаад гэвэл энэ нь гаднынханд гоё харагдах гээд

байгаа биш Монгол иргэний эрх ашиг ингэж байж л хамгаалагдана. Үүнийг бид нар дотроо хянаж чадахгүй бол тэр гаднын байгууллагуудаас дүгнэлтийг нь авч үзэх хэрэгтэй. Тэгэхээр энд, тэр дүгнэлтүүдтэй та нар хэр танилцсан. Аль, аль байгууллагын дүгнэлтүүдтэй та нар танилцаад, түүн дээр дүгнэлтээ хийгээд, дараа нь бидний бодлого ийм байх ёстой юм байна гэж бодлого гаргасан. Ингээд 2 асуулт.

Өөрөөр өөрөөр хэлбэл аль аль байгууллагуудын дүгнэлтийг үзсэн. Энэ дээрээ үндэслээд та нар ямар бодлого гаргаж байгаа вэ? Энэ үзүүлэлтүүдийг сайжруулах талаар юу хийж байна вэ? Энэ ингээд 2 асуулт.

3 дахь асуулт нь, яг танай энэ хороон дээр хүний эрхийн чиглэлээр та нар, мэдээж бүгдээрээ хүний эрхийн тодорхой мэдээлэлтэй байж байгаа. Гэхдээ энэ юм чинь 1 байрандаа зогсдоггүй, байнга хөгжиж байгаа учраас энэ дээр тогтмол хүний эрхийн чиглэлээр сургалтууд танай дээр явагдаж байгаа юу? Яагаад гэвэл эргээд та нарын тэр ажиллаж байгаа тэр шүүх байгууллагууд чинь бол нэгдүгээрт, хүний эрхийг хамгаалах чиглэлийн байгууллагууд байгаа. Тэгэхээр тэд нар ажлаа зөв хийж чадаж байна уу, үгүй юү гэдгийг та нар ойлгохын тулд өөрсдөө үүнийгээ яг цаг тухайн байнгын мэдлэгтэй тэгээд энэ өөрчлөгдөж байгаа орчноо аягүй сайн мэдэрдэг байх ёстой. Тийм учраас энэ дээр ямар нэгэн тогтмол сургуулилт явуулдаггүй гэсэн ийм 3 асуулт байна.

Б.Энхбаяр: 4 номерын микрофон.

Х.Хашбаатар: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Таны хэлсэн үнэн. Бас хараат бус байдлыг хангах 1 хөшүүрэг бол сахилга баттай байх. Тэгэхээр ер нь бол Монголын шүүх бас нэлээд ачаалалтай юм байна. Тухайлбал энэ 2022 оны байдлаар 100-аад мянган хэрэг шийдвэрлэсэн байна. 100-аад мянга, 1 жилийн хугацаанд. Үүнээс бол

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

давж заалдах шатад 16% буюу үүний 16% орчим нь өргөдөл давж заалдсан байна, шийдвэрээс, үлдсэн 8.6% нь бол хяналтын шат нь Дээд шүүхэд хандсан ийм үзүүлэлттэй байдаг юм байна. Эндээс харахаар шүүх бол өөрөө ачаалалтай байгаа. Монголд одоогоор бол 511 шүүгч ажиллаж байна. Шүүхийн сахилгын хороо энэ хугацаанд бас өргөдөл сая 416 өргөдөл ингээд шалгалаа гээд үзэхээр 1 шүүгчид 1 бараг өргөдөл ирэхээр тийм хэмжээний өргөдөл бол Сахилгын хороо гэдэг байгууллагыг таньж мэдсэн, сахилгын хороонд хандах хандлага нь ихэссэн. Үүний ихэнх нь бол шүүхийн шийдвэртэй холбоотой байгаа учраас бид нар 245-ыг бол татгалзаж шийдвэрлэсэн байгаа.

Энэ шүүгчийг сая та бас хэлж байна. Ил далд байдлаар улс төрчид болон удирдах албан тушаалтнууд дуудаж шийдвэр гаргахад нь нөлөөлдөг өө гэсэн агуулга бүхий юм. Үүнийг Шүүхийн тухай хуульд зохицуулж өгсөн. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан албан тушаалтнууд буюу энэ төрийн өндөр улс төрд нөлөө бүхий албан тушаалтнууд шүүгчтэй уулзах тохиолдолд тэмдэглэл хөтлөх тухай зохицуулалт. Мөн дээр нь энэ ШЕЗ болон Шүүхийн сахилгын хорооны гишүүд бас энд хамаатай ийм зохицуулалт өгсөн байгаа. Энэ чиглэлийн үнэхээр бас бусдаас чиглэл авсан, бусдад урьдчилж тийм шийдвэр гаргасан агуулга бүхий мэдээлэл байдаг бол манай байгууллагад бас хандах боломжтой. Бид үүнийг шалгаж нягтлах боломжтой гэдгийг бас танд илэрхийлмээр байна.

2 дахь асуулт. Сүүлийн үед бол шүүхийн нэр хүндийн талаар судалгаа, авлига, ашиг сонирхолд өртсөн талаар судалгааг бол хэд хэдэн байгууллага хийсэн байдаг. АТГ-аас жил бүр хийдэг судалгаа, хамгийн сүүлчийн байдлаар Нээлттэй нийгэм форумаас хийсэн судалгаа байна. Үүгээр бол нэг шүүхэд итгэх итгэл нь 51.5%-тай гэсэн ийм

судалгаа гарсан байдаг. ШЕЗ өөрсдөө бас хийж үзсэн байдаг. Бас ШЕЗ-ийн хийсэн судалгаагаар бол 61 аравны хэдтэй гарч байгаа. Энэ бол харилцан адилгүй. Үүний шүүхэд итгэх итгэл яагаад энэ муу байна гэдэг агуулгыг нь тодруулаад асуулгаар асуухаар шүүхээр үйлчлүүлсэн этгээд 10 хүний 1 орчим хувь нь л байдаг. Ихэнх тохиолдолд мэдээллийг хаанаас авсан байдаг гэхээр цахим хэрэгсэл буюу дам эх сурвалжаас авсан, шүүхээр үйлчлүүлсэн этгээдүүд энд итгэх итгэл дээр нь бол их бага үзүүлэлт гарч байгаа. Тэгэхээр ер нь бол яах вэ, цахим хэрэгсэл дээр үндэслээд шүүх рүүгээ бас үндэслэлтэй, үндэслэлгүй нь мэдэгдэхгүй ийм агуулгаар хандахаар иргэдэд бас тэр мэдээлэл нь бас очсон үндэслэл дээр бас энэ судалгаа гардаг юм байна гэдгийг бас харсан. Энэ дээр бас бид нар дүгнэлт хийгээд цаашидынхаа сахилгын хорооны ажиллах чиглэл, стратеги бодлогоо бас бид боловсруулж байна. Энэ чиглэлээр цаашид яаж ажиллах вэ, ШЕЗ-тэйгөө яаж ажиллах вэ, Улсын дээд шүүхтэй яаж ажиллах вэ гэдэг агуулгаа бид үүгээрээ тодорхойлох гэж оролдож байгаа.

Дараагийн 3 дахь асуулт нь хүний эрхийн чиглэлээр. Ер нь бол Шүүхийн тухай хуульд Шүүхийн сахилгын хорооны гишүүн тогтмол сургалтад хамрагдаж өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр үүрэг болгосон заалттай. Энэ хүрээнд бид нар бас нэлээдгүй тухай бүрийн жилийн төлөвлөгөөнд бол тусгаж ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн нэмж тодруулъя.

Д.Цогтбаатар: Тийм, тэгэхээр би асууж байгаа юм ийм шүү. Та надаа ингээд хууль ярив уу? Хууль дээр манайх чинь бүх юм байгаа шүү дээ, асуудал чинь хууль тийм байхад хуулийг биелүүлэхгүй өөрөөр яваад байгаа энэ тохиолдлуудыг л ярьж байгаа шүү дээ. Та жишээлбэл хүний эрхийн сургалтад хамрагдах үүрэгтэй тэр хуульд заачихсан байгаа гээд миний асууж байгаа бол хуульд юу

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

гэж заасныг чинь биш, тэрийгээ хэр хэрэгжүүлж байгаа вэ гэдгийг л асууж байгаа I юм.

2 дахь энэ байна шүү дээ, танайх ингээд шийтгэл оногдуулсан 50% гэхэд 21 шүүгчид юу оногдуулсан шийтгэл нь хүчин төгөлдөр болсон өөрөөр хэлбэл биш нөгөө оногдуулсан шийтгэл 50% байна л даа. Тэгээд 21% гэдэг чинь ихэнх нь юу байгаад байна шүү дээ 50% ер нь тэр шийтгэл чинь эргээд хүчин төгөлдөр болоогүй байгаад байна. Гарсан тэр шийтгэл болгоны 50% нь 2-ын ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн асууж байна. Сая танай тайланд байгаа нийт 40 шүүгчид сахилгын шийтгэл ноогдуулснаас 50% нь буюу 21 шүүгчид оногдуулсан шийтгэл нь хүчин төгөлдөр болсон байна гэдгийг Цогтбаатар гишүүн тодруулж асууж байна. 4 номерын микрофон хариулах уу?

Х.Хайбаатар: Өмнөх 3 дугаар асуулт сая микрофон тасраад хариулж чадсангүй. Канадын Эзэн хааны дээд шүүхтэй бид нар хамтраад сая 2023 оны 3 сард жендерийн тэгш байдлын чиглэлээр бас энэ чиглэлээр сургалт зохион байгуулсан байгаа. Энэ зөвлөгөөн бас мөн зохион байгуулж ажилласан байгаа. Энэ чиглэлээр гишүүдийг бас бүрэн бүр дүүрэн хамруулсан.

Энэ 40 шүүгчид холбогдуулаад түүнээс 21 шүүгч нь хүчин төгөлдөр болсон гэдэг нь манай процесс нь Шүүхийн сахилгын хорооны хуралдаанаар 40 шүүгчид хариуцлага тооцсон. Мөн дотроо 2 шүүгч 1 шүүгч бусдаа буюу хянан үзэх хуралдаан гэж давхар явагддаг, хянан үзэх хуралдаан. Энэ хянан үзэх хуралдаанд давхар хариуцлага тооцогдсон шүүгч буюу оролцогч гомдол гаргадаг. Энэ гомдол бол 2022 оны 10 ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Шүүхийн сахилгын хороо бол шүүгч нарын сахилга баттай холбоо, ер нь шүүгч нар сахилга баттай байна гэдгийг та бүхэн юу гэж ойлгож байгаа юм? Яг шүүгч нар сахилга баттай байна, сахилга батгүй байна гэдгийг юугаар хэмжих вэ? Хуулиар олгогдсон тэр эрх хэм хэмжээ мөн үү? Сахилга баттай байх асуудалд нь шүүгчийн ёс зүйн асуудал орж байна уу? Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль хэлэлцэгдээд явж байна. Ёс зүйн төрийн албан хаагчийн хэм хэмжээ, шалгуур шаардлагыг зөрчсөн энэ үйлдэл сахилгын хороогоор орж ирсэн үү? Ёс зүйтэй холбоотой. Та нарын энэ гаргасан тоо баримтуудад ёс зүйтэй холбоотой асуудал хөндөгдсөн үү гэдгийг 1-д асууя.

2-т, та сая тайлангийнхаа хамгийн сүүлд төрийн хэмнэлтийн хуулийг бас эргэж харах. Шинээр байгуулагдаад жил болж байгаа манай байгууллагын хувьд бас хүндрэлтэй байна гэдэг бас эргэж харах асуудал, энэ чинь юу гэсэн үг вэ? Хуулийг ялгамжтай шинээр байгуулагдсан танай байгууллагад төрийн хэмнэлтийн хуулийг бас өөр байдлаар авч хэлэлцэх, тэр худалдан авалт юмнуудыг нь Шүүхийн сахилгын хороон дээр өөр байдлаар хэрэгдэх бололцоо боломжийг нь илүү давуу эрхтэй олгоно гэсэн үг үү? Ямар санал тавьж байгаа юм, би тэрийг ойлгосонгүй үүнийгээ 1 та бүхэнд тайлбарлаж өгөөч.

Нөгөө талаар Шүүхийн тухай хууль хэрэгжээд 2 жил, танай байгууллага жил орчим болж байна. Ер нь олон нийтийн дунд шүүгч нарт итгэх итгэл, шүүхэд итгэх итгэл дээшилж байгаа ийм зүйл ажиглагдаж байна уу, танай байгууллагаас хийсэн судалгаа юм байна уу? Үнэлэмж ямар байна, шүүгч нарын. Хэл аманд орооцолдсон шүүгч нарт ямар арга хэмжээ авагдсан, тухайлбал тэр 1 лифттэй холбоотой асуудалд холбогдсон шүүгч нарт, элдэв янзын хэл аманд орооцолдсон шүүгч нарын асуудал ямар шатандаа явсан, яаж

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шийдэгдсэн. Нийт дүнгээрээ шүүхэд 1 жоохон агаар орох, эрүүл бие даасан, хараат бус шударга байх, итгэл төрөх, цаашидаа 1 үнэхээр нь бас 1 арай өөр болж байгаа юм байна гэдэг 1 ийм байдал ажиглагдаж байна уу, ажиглагдахгүй байна уу? Шүүхийн салбарт. Та бүхэн үүнийг бас ёс зүй, сахилга батыг нь мөрдүүлж чадаж байна уу, чадахгүй байна уу? Цаашидаа энэ сахилгын хороо байгуулагдаад ингээд явахад ер нь давуу болон сул тал нь юу байна, юу байна? Хуулийн гогцоо гэдэг юм уу, хязгаарлалт хаалт юмнууд юу байна? Ийм боловсруулсан юмнууд байна уу? Энэ дээр та бүхэн 1 саналаа хэлээч. Баярлалаа.

Б.Энхбаяр: 4 номерын микрофон.

Х.Хашбаатар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Өмнө нь бол Шүүхийн эрх зүйн байдлын тухай хуулиар шүүгчийн ёс зүйн байдлыг зохицуулж ирсэн. Шинэ шүүхийн тухай шинэчилсэн найруулгаар бол сахилга баттай холбоотой энэ зөрчлийг бол оруулж өгсөн. Энэ 40 зөрчил дотор ёс зүйн чиглэлийн зарим заалтууд бол орж ирсэн мөн нэгтгэгдэж. Гэхдээ өмнө нь эрх зүйн байдлын хуульд заасан шүүгчийн ёс зүйн дүрмээр зохицуулагдаж байсан зарим заалт бол энд байхгүй байгаа. Тухайлбал зохисгүй байдал. Та сая асуулаа. Нөгөө лифтний асуудалтай холбоотой шүүгч нартай холбоотой иймэрхүү үйлдэл дахин гарвал энэ бол ёс зүйн асуудал. Үүнийг яг зохицуулсан бас зохицуулалт бол энэ хуульд бол бас байхгүй. Зохисгүй байдал гэж өмнө нь Ёс зүйн дүрмээр зохицуулж байсан. Энэ бол хуульд байхгүй.

2 дугаар асуудал. Төрийн хэмнэлтийн хууль бид нарт хүндрэлтэй байгаа талаар дурдсан. Бид худалдан авах талаасаа биш манай байгууллага ШЕЗ-өөс өмнө 1 нэгж байж байгаад салж ирсэн. ШЕЗ-өөс зарим ширээ, сандал, эд хогилыг бол бид хүлээж авсан. Орон тоо бас жоохон нэмэгдсэн учраас зарим зүйлээр бас хүрэлцээгүй байсан. Энэ дээр

бас жоохон худалдан авах ажиллагаа дээр бас хүндрэлтэй байсан. Өмнө нь ажиллаж байсан уламжлагдаж байсан байгууллагуудад бол энэ бол асуудал шийдэгдчихсэн байхад шинэ байгууллагад жоохон ийм хүндрэл учирдаг юм байна гэдэг агуулгаар.

2 дугаарт, сая сургалтын асуудал яригдаж байна. Сургалтаар бид нар бас хийх ёстой гээд. Энэ төрийн хэмнэлтийн хуульд ч гэсэн бас цахим сургалтыг давамгайлна. Танхимын сургалтыг бол аль болох хязгаарлах талаас нь энэ тэр зохицуулж өгсөн байгаа. Энэ дээр бол шинэ тутам байгууллагад бас иймэрхүү хүндрэл зэргийг учирч байгаа гэдгийг бас дурдах гэсэн юм.

2 жил боллоо. Энэ хугацаанд бид нар ямар хариуцлага тооцсон юм бэ гэж байна. Та бүхэн энэ дэлгэц рүү бас анхаарвал энэ бас Шүүхийн сахилгын хороо байгуулагдсанаас хойших үр дүн харагдах байх. Өмнө нь Ёс зүйн хороо байхад сүүлийн 5 жилээр бид нар хийсэн байгаа юм. Сахилгын хороо энэ тоон дээр ингээд харагдахаар та бүхэнд бас хүснэгтээр хүргүүлчихсэн байгаа юм. Тухайлбал 2015 онд Ёс зүйн хороогоор 14 шүүгчид сануулах арга хэмжээ 11, цалингийн 3 шүүгчид хариуцлага тооцоод энэ нь шүүхээр бас давж заалдаж шийдвэрлэгдсээр байгаад нэгхэн шүүгч хүчин төгөлдөр болсон. Тэгээд 14 шүүгчээс 1 шүүгчид хариуцлага тооцоод 7.1 нь хүчин төгөлдөр болсон байна гэх мэтээр энэ тоог бол та бүхэн харж болно.

2022 оны байдлаар бол бид үзэх юм бол 40 шүүгчид хариуцлага тооцоод, 28 шүүгч одоогийн байдлаар энэ 28 гэдэг нь өнөөдрийн байдлаар орчихсон байгаа юм. 28 шүүгчид хариуцлага нь хүчин төгөлдөр, түрүүн бол 21 гэж байсан нь 12 сарын 31-ний байдлаарх гэсэн тоо байгаа. Энэ ямар шалтгаантай байна вэ гэхээр нөгөө тухайн оролцогч шүүгч би энэ зөрчлөө хүлээн зөвшөөрөхгүй байна гээд хяналтын шатаар гомдол гаргадаг. Мөн дээд

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шүүхэд гомдол гаргадаг. Одоо Дээд шүүхэд 5 шүүгчийн асуудал бас хянагдаж байгаа. Үүнийг бас дурдах нь зүйтэй байх.

Шүүхийн сахилгын хороо бие даасан байдлаар үйл ажиллагаагаа явуулахад бас багагүй хугацаанд бас өөрсдийгөө таниулах шүүгчтэй холбоотой сахилга хариуцлагыг бас оногдуулах чиглэлээр нэлээдгүй ажил хийсэн. Сая энэ тоо бас харагдах байх. Энд бол бас шүүгч нар дунд бас хариуцлага алддаг, шүүхийн нэр хүндийг унагадаг, шударга бус ханддаг ийм шүүгч нар байна. Энэ чиглэлээр нь бид нар бол бас хариуцлагыг нь тухай бүр нь тооцоод цаашдаа гарах үр дүн бол энэ 40 гэсэн тоо бол багасах болов уу гэж ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Энэ тоо их сайн тоо харагдаж байгаа юм. Зүгээр тоо талаасаа статистик тоо талаасаа. Нөгөө талаасаа Сахилгын хороо байгуулагдсанаар энэ шүүхийн салбарт энэ огт илэрдэггүй байсан гомдлын чинь тоо бол эрс нэмэгдчихсэн байгаа байхгүй юу, өмнөх онуудтай харьцуулахад. Тэгэхээр үүнийг юу харж байна вэ гэхээр ерөөсөө 1 баахан ингээд шинээр ингээд гомдол юмнууд өгдөг болоод эхэллээ. Энэ хуулийн хүрээнд ингэлээ гэж байгаа юм уу, эсвэл нийтлэг ер нь шүүгч нарт ийм сахилга батгүй байсан асуудлууд нь одоо ингээд илрээд эхэлж байна уу. Энэ дээр юу гэж бодож байна?

Ер нь гэв гэнэтхэн энэ жилээс 22 онд л гэв гэнэтхэн Сахилгын хороо сайн ажиллаад ингээд гомдол мэдээллийг аваад шүүгч нарт хариуцлага оногдуулахад өмнө нь 14 байсан бол энэ жил 40 болоод ингээд оногдуулахад явж байсан хариуцлага оногдуулахад явж байгаа нь нийтээрээ сахилга батгүй байгаад энэ нь шинэ хуулиар илрээд харагдаад байна гэж ойлгох уу?

Б.Энхбаяр: 5 номерын микрофон.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Шүүхийн сахилгын хорооны гишүүн Ариунтуяа Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Ер нь бол бид өнгөрсөн онд 423 өргөдөл авсан. Энэ бол маш том тоо. Тэгэхээр энэ нь бол 1 талаасаа бол Шүүхийн сахилгын хороо байгуулагдаад бие даасан хараат бусаар байгуулагдаад ингээд сахилгын хороо үйл ажиллагаагаа явуулахдаа нийтэд, иргэдэд нээлттэй явуулсны үндсэн дээр бас иргэд маань энэ байгууллагыг мэдээд их хэмжээгээр бол гаргаж байгаа гэж 1 талаас харагдаж байгаа.

Нөгөө талаасаа яг өнөөдрийн байдлаар Монгол Улсад 511 шүүгч ажиллаж байгаа, 117 шүүхэд. Тэгэхээр 511 шүүгчээс ганихан жилийн дотор давхардсан тоогоор 423 өргөдөл ирнэ гэдэг маань өнөөдөр бас сахилга ёс зүйн хувьд бас иргэдийн итгэл бол бас нэлээд доогуур хэмжээнд байна гэдэг нь харагдаж байгаа. Жишээлбэл 23 оны эхний улиралд гэхэд бид нар өнөөдрийн байдлаар 150 өргөдөл аваад байна. Тэгэхээр ингээд эндээс харахад бол сахилгын хороо байгуулах ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Нэмж хариулъя, 5 номерын микрофон.

Д.Ариунтуяа: Хуулийн заалтууд нь маш тодорхой болоод тэгээд бие дааснаар ажиллаж байгаа гэдгээрээ бол энэ нь бол илүү их байгаа байх гэж харагдаж байгаа. Нөгөө талаараа бас 1 асуудал байгаа. Одоо ингээд албан тушаалтантай уулзаад байгаа та нар шүүгчийг яах вэ гэдэг. Өнөөдрийн хуулиараа Шүүхийн сахилгын хороо зөвхөн өргөдөл мэдээлэл гаргачихсан тохиолдолд л тэрийг шалгах эрх нь байгаа. Түүнээс биш ямар нэгэн мэдээлэл ингээд гарахад тэр мэдээллийн хүрээнд шалгах эрх нь бол бид нарт хуулиар байдаггүй. Тэгэхээр бид нар мэдээлэл ингээд сонсоод байдаг, түүний дагуу

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

өргөдөл мэдээлэл ирэх юм бол бидэнд бол шалгах эрх байхгүй байгаа. Тэгэхээр Шүүхийн тухай хууль ер нь сайн хууль болсон. Гэхдээ бол яг ингээд практикт хэрэглээд эхлэхээр энэ асуудал бол гарч байгаа. Тэгэхээр түрүүн Цогтбаатар гишүүн бас асууж байсан. Яг энэ асуудлыг бид нар сонсоод байдаг. Өргөдөл ирэхгүй бол шалгах эрх нь бол байхгүй байгаа энэ асуудал дээр хэлье.

Мөн дахиад нэмж хэлэхэд Нямбаатар гишүүний асуулт дээр би хариулъя. Мэргэжлийн алдааг яах вэ гэж байгаа юм. Мэргэжлийн алдааг өнөөдөр бас Сахилгын хороо бол авах нь зүйтэй гэж миний зүгээс бол гишүүний хувьд хардаг. Яагаад гэх юм бол илтэд хууль бус шийдвэр гаргачихдаг. Тэгэхээр өнөөдөр Шүүхийн сахилгын хорооны гишүүн ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Нэмэлт асуултад хариулах хугацаа 1 минут байгаа, дэгээрээ. Тэгээд 2 удаа хариулчихсан байна.

Адъяаа гишүүн асуултаа асууя.

Ш.Адъяаа: Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуулийн бүтцийн байгууллага анх энэ хурал байгуулсан, хуулийг нь баталж өгсөн. Тэгээд энэ Шүүхийн сахилгын хороо гэдэг энэ байгууллагын тайланг бид ХЗБХ танилцаж байгаа юм. Тэгэхээр энэ шинэ байгууллага бас шинэ сорилтуудтай тулгарч байгаа. Монголын өнөөдрийн шүүхийн системийн үйл ажиллагаа, шүүх шударга байх, шүүх бие даасан байх, шүүх хараат бус байх гэдэг энэ үйл ажиллагааг бид Үндсэн хуулийн 19 оны өөрчлөлтийн дагуу УИХ баталсан. Тэгээд өнөөдрийн энэ анхны тайланг хэлэлцэж байна. Энд сайн, муу зүйл олон байгаа. Бид энд олон талаас нь ярьж хэлж, бас цаашидаа энэ Үндсэн хуулийн бүтцийн байгууллага бэхжүүлэх, хараат бус байх асуудлын төлөө бас УИХ, төрийн эрх барих дээд байгууллага түүний ХЗБХ бид бас энд нэлээн сайн дүгнэлттэй бас бодлоготой

байх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Эндээс нэг 2, 3 зүйлийг тодруулъя. Тэр Шүүхийн сахилгын хорооны эрх хэмжээний асуудал дээр тэр мэргэжлийн алдаа гэдэг асуудлыг Шүүхийн сахилгын хороон дээр бас тодорхой хэмжээгээр судлах, шалгах ийм чиг үүрэгтэй энэ хуулийн бас ийм заалт байгаа. Тэгэхээр энэ өнөөдөр шүүхийн шийдвэрийг хянана гэсэн үг биш. Тэгэхдээ энд бас хэрэг маргааныг шийдсэн байдал, алдаа дутагдлыг харах бас шинэ цонх гэж ойлгож байгаа. Үүнийг бол бас цаашидаа УИХ бас энэ дээр тодорхой хуулийн зохицуулалт хийх ёстой байх гэж бодож байгаа.

Өнөөдөр тэр хонгилын шүүгч, шүүхийн мафи гэдэг тэр иргэдийн дунд яриад байгаа асуудал өнөөдөр амь бөхтэй оршсон хэвээрээ л байгаа гэсэн ийм хувийн бодолтой байдаг. Яагаад гэхээр өнөөдөр анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх 2 бол хэрэг маргааныг өөр өөр хэлбэрээр ингэж шийддэг ийм баримтууд зөндөө байгаа. Тэгэхээр энд асуудлыг цаашидаа ер нь яах вэ гэдэг дээр энэ ямар байр суурьтай байна аа?

Тэгээд тэр төрийн албаны ёс зүйн тухай хууль гэдэг энэ хууль өнөөдөр УИХ батлагдана. Тэгэхээр тэр шүүхийн сахилгатай холбоотой юм бид нар ёс зүйтэй холбоотой асуудал чинь энд хамрагдаад явна. Энэ бол нэлээн хатуу хууль батлагдаж байгаа, энэ дээр бас сайн 1 санаа зовох хэрэггүй байх гэж бодож байна.

Дээр нь энэ цалин хангамжийн асуудал. Энэ тусгай чиг үүргийн байгууллага гэж би ойлгож байгаа. Энэ цалин хангамж цаашидаа энэ шинэ байгууллага дээр ямар бэрхшээл учирч байна аа? Бид бол өнөөдөр 1 байгууллагыг байгуулж өгчхөөд л сайн ажилла гэж шаарддаг. Гэтэл тэр хараат бус байх, асуудлын гол асуудал бол цалин хангамж тэр хүний ажиллах нөхцөлийн асуудал

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа юм. Энэ дээр ер нь ямархуу байна аа? Ийм энэ төсөв хөрөнгөөрөө, энэ бүтцээрээ, энэ Үндсэн хуулийн бүтцийн хамгийн энэ шүүгчтэй холбоотой, шударга шүүхтэй холбоотой асуудлыг цаашид явуулах тийм боломж байна уу гэдэг ийм 1 асуудлыг асууя гэсэн ийм бодолтой байна.

Б.Энхбаяр: 4 номерын микрофон.

Х.Хашбаатар: Адьшаа гишүүний асуултад хариулъя. Түрүүн ерөнхийдөө бас дэлгэрэнгүй хэлсэн. Мэргэжлийн хорооны чиг үүргийн зарим асуудлыг бол бид 3 зүйл дээр бас зөрчил гэж тооцож орж ирдэг. Шүүхийн шийдвэр хянахгүйгээр бас илтэд зөрчилтэй энэ асуудлыг бас сахилгын хороо хянаж байх нь бол зүй ёсны хэрэг. Бид бол сая саналаа хэлсэн.

Цалин хангамж, материаллаг тал дээр бид ХЗБХ бол бас энэ тал дээр нэлээдгүй дэмжиж байгаа. Ноднингийн бас төсвийн тодотголоор бид нарын бас дутагдалтай байгаа зарим материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр тодотголд бас ХЗБХ дэмжиж өгч энэ хэвээр нь бас баталж өгсөнд бид бас та бүхэнд бас талархаж байгааг энэ ялдамд илэрхийлье. Ер нь цаашидаа бол бэхжүүлэхэд бас материаллаг болон ийм үйл ажиллагаанд дэмжлэгтэй байгаа асуудал дээр бол бас ХЗБХ-ноос бас дэмжиж ажиллахыг бас та бүхнээс бас хүсэж байна.

Б.Энхбаяр: Адьшаа гишүүн тодруулж асууя.

Ш.Адьяа: Би 1 зүйлийг асууя даа. Энэ хэвлэл мэдээллээр энэ шүүгч нарын холбоотой ялангуяа энэ Дээд шүүхийн шүүгч нартай холбоотой өргөдөл гомдол маш олон нийтийн сүлжээ хэвлэлээр их гарч байгаа. Энэ асуудлыг ер нь яаж шийдэж байгаа вэ? Ялангуяа тэр Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Соёмбо-Эрдэнэ гэдэг хүнтэй холбоотой асуудал сүүлийн олон хэвлэл мэдээлэл сошиалаар ингээд яваад байна. Тэгээд үүнийг тэр

ШЕЗ-ийнхөн дардаг гэсэн л ийм л мэдээлэл яваад байгаа юм. Тэгэхээр би бол хэвлэлийн мэдээний хүрээнд, сошиалын мэдээний хэвлэлд хүрээнд байгаа. Тэгэхлээр энэ асуудал дээр яг тийм хэрэг маргааныг нь яаж шийдсэн юм. Яагаад одоо хуртэл тэр шийддэггүй юм. Дээд шүүхийн шүүгч болохоор айдаг юм уу, 1 бол Дээд шүүхийн төлөөлөл болохоор үүнийг нь хамгаалдаг юм уу, энэ талаар 1 тайлбар авъя. Би зүгээр надад хувийн ашиг сонирхол байхгүй. Тэгэхдээ энэ хууль дээдлэх ... /минут дуусав/

Б.Энхбаяр: 4 номерын микрофон.

Х.Хашбаатар: Улсын дээд шүүхийн шүүгч нартай холбоотой бол гомдол ирдэг ээ. Түрүүн тоо бүртгэл дээр бас гарч байсан, хяналтын шат буюу Улсын Дээд шүүхийн 26 шүүгчид холбогдох гомдлыг бас шалгаж шийдвэрлэсэн байна. Тэгэхээр тухайлсан Улсын Дээд шүүхийн шүүгч нарын холбоотой өргөдөл гомдлыг сахилгын хороо шалгадаггүй гэсэн асуудал бол байхгүй байна, одоогоор.

Соёмбо-Эрдэнэ гэж шүүгчтэй холбоотой ямар өргөдөл байгааг бас тодотгож үзэх юм бол бид танд бас эргэж хариу мэдэгдье. Тодорхой бас хариу өгье өө, жич.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа.

Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Адьяа гишүүн, Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Одонтуяа дарга үгээ хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр би УИХ-ын дэд даргын хувьд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн асуудлыг цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын даргаар ажилладаг. Энэ хугацаанд бол үгүй ээ, одоо Монголчууд бид чинь ямар их хүнээ хэлмэгдүүлж

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байсан юм бэ гэдгийг бол ойлгодог. Ер нь 1930-40-өөд оны хувьд бол нийгэм тэр чигээрээ айдас хүйдсээр ингээд амьсгалж байсан цаг үе байдаг юм. Одоо өнөөдөр ингээд театрт Хөгжлийн банкны хэргээр ингээд хэдэн мянгаар нь ингээд бизнес эрхлэгчдийг суулгачхаад ингээд шүүх хурал хийж байгаатай адилхан яг энэ ордны энэ суурин дээр Бөмбөгөр ногоонд тэр Гэндэндэмидийн хэрэг, лам нарыг ингээд олноор нь ингээд хийж байсан. Би бол юуг хэлэх гээд байна гэхээр ер нь нийгэм өнөөдөр сошиал ч бас хөгжчихлөө. Бас I тиймэрхүү айдас хүйдэстэй юм руу яваад байна шүү. Ер нь энэ нийгэм ингээд л үзэхээр л тэрийг хорино, тэрийг яллана гээд тэгээд энэ бүх зүйл. Тэгэхээр I тоо баримт. Жишээлэхэд Монгол Улс хэлмэгдсэн иргэдийнхээ тэр ял сонссон иргэдийнхээ 80 хувийг цаазалсан байдаг байхгүй юу. Энэ бол аймшигтай тоо байхгүй юу. 80 хувийг нь. Тэгэхээр энэ цөөхөн Монголчууд чинь өнөөдөр тэр гашиун юмнаасаа сургамжаа авах ёстой юм. Одноо юм л бол шүүнэ, хорино, яана гэсэн ийм зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр би бол зүгээр юу хэлэх гээд байна гэхээр I их цалин мөнгөндөө ч биш шүүгчийн ёс зүйтэй л хүн шүүгч хийдэг гэдэг ойлголтыг л нийгэмд бид нар бүрдүүлэх ёстой. Үүнийг л анхаарах ёстой. Түүнээс тэр цалин мөнгө бол наядугаар асуудал. Ерөөсөө энэ ёс зүйтэй хүмүүс чинь шүүгч болдог юм байна гэдгийг бид нар бүгд нийгмээрээ ойлгож хүндэлдэг ийм байхгүй бол одоо ерөөсөө шүүх рүүгээ бас дайрдаг болчихсон. Тэгэхээр та нар хэлж байна шүү дээ, шүүхэд нөлөөлөхийг хориглоно гээд. Тэгэхээр манай яг энэ Төрийн ордонд сууж байгаа хүмүүс үүгээрээ өөрсдөө бас үлгэрлэх ёстой юм. Би бол энэ дээр Ерөнхий сайд дээр шүүмжлэлтэй ханддаг, Нямбаатар сайд дээр шүүмжлэлтэй хандаж байна, АТГ-ийнхан байна. Ерөөсөө өөрсдөө гараад л энэ хэрэг дээр шүүх яаж шийдэхийг харна гэж ингэж хэлж болохгүй байхгүй юу даа. Энэ чинь шүүхэд нөлөөлж байна. Эсвэл гараад баахан хүнийг зарлачихдаг. Тэгээд л нийгмээрээ тэгээд нөгөө ЗГ-ын мэдээ

юм болохоор энэ чинь ингээд нийгмээрээ давлагаалж тэр чинь сэвэгдэж байна шүү дээ. Тэгээд өнөөдөр энэ Монголд чинь тийм гэм буруугүй хүн ер нь үлдэж байгаа юм уу? Үүнийг яах юм? Түүний хэргийг тэгж шийдсэн юм чинь одоо түүний хэрэг яаж шийдэхийг та нар харж байхгүй юу. Ингэж болохгүй. Энэ чинь сошиалаар эхлээд ялалчаад дараа нь тэр шүүгч чинь тэр чинь сэтгэл санааны бас асуудалд орж байна шүү дээ. Шүүхэд ингэж бид нар нөлөөлж бол болохгүй. Тэгэхээр энэ асуудал дээр цаашидаа яах ёстой юм, онцгой анхаарч ажиллах ёстой, шаардлагатай тэр хуулиудаа оруулаад ир бид нар дэмжээд өгье, хэлэлцээд өгье гэж байгаа.

Яагаад гэхээр хүний эрхийн асуудал энэ дээр яагаад чухал юм бэ гэхээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч гээд ер нь I хүний асуудал I талд байхад нөгөө талд бол мөрдөх байгууллага, прокурор, шүүх, ШШГБ гээд 4 том тогтолцоо ажиллаж байгаа. Тэгэхээр энэ том тогтолцооны эсрэг бид нар хүнээ хамгаалахгүй бол дийлэхгүй шүү дээ. Одоо ерөөсөө тэр захиалгатай шийддэг хонгил чинь бүүр гаарч байна шүү дээ. Үүнийг чинь ингэж болохгүй юм. Тэгээд энэ ни араа хийхдээ ч гэсэн бодолтой хийж бай, та нар. Хүнийг чинь эргээд тэр хүний хохирлыг сэтгэл санааны хохирлыг чинь хэзээ ч нөхдөггүй байхгүй юу.

Нөгөөтээгүүр I чухал зүйл ярихад өнөөдөр 4 дүгээр асуудал дээр хэлэлцэх юм. Тэр шүүхийн шийдвэргүйгээр баривчилдаг асуудал бол маш их байгаа тийм үү? Үүнийг бол дараа тусад нь ярина. 2 дахь асуудал бол би шүүгч нарт хэлээд байгаа. Цагдан хорих асуудал чинь одоо маш ноцтой байдалд орчихлоо. Өчнөөн сар хоригдчихоод ганцхан удаа байцаалт авсан, өчнөөн сар хоригдчихоод шүүх хурал нь болдоггүй. Ингэж Монгол хүнийг ингэж мохоодог, ялладаг энэ байдлаа больчих л доо. Шоронжуулдаг аа. Үгүй ээ Монголчууд чинь хэдхэн л хүн байгаа шүү дээ, 3.3 сая хүнээсээ хүүхдээ хасчих, гэртээ тэр тэтгэвэртээ байгаа

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүмүүсийг хасчих, хэдэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ хасчих. Үгүй ээ 1 хэдхэн хүн дээр 100 ямаанд 60 ухна, хэчнээн прокурор хэдэн тэрбумын зардал гаргаад энэ цөөхөн хүн чинь ажиллаж, амьдармаар байна шүү дээ. Айдасгүй амьдармаар байна шүү дээ.

Одоо төрийн албан хаагч лайк дарахад хүртэл араас нь дарга нь очдог ийм систем рүү явмааргүй байна. Энэ чинь яг нөгөө хэлмэгдүүлэлт рүү аваачдаг юм. Тийм учраас энэ хуулийн төслүүдээ хурдан хэлэлцмээр байна. Пүрэвдорж гишүүний тэр оруулсан нөгөө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль хурдан батлахгүй бол энэ чинь ийм юм руу л яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар хүний эрхтэй хуулиудаа яагаад батлахгүй ингээд хойш нь тавиад байгаа юм бэ гэдгийг би бас хатуу хэлмээр байна. Шүүгчдэд. Энэ асуудлаа яаралтай оруулж ир.

Өнөөдөр тэр 70 он, 60 он, 30 хэдэн оны юм чинь ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Адьшаа гишүүн үгээ хэлье.

Ш.Адьяа: Шүүхийн сахилгын хорооны тайланг бид нар хэлэлцэж байна. Тэгэхээр Шүүхийн сахилгын хороо гээд энэ Үндсэн хуулийн байгууллага байгуулагдаад бас жил гаруй хугацаанд бас тодорхой ажлуудыг хийсэн, бас олон шийдэл эрсэн асуудлууд байгаа тухай энэ мэдээллийг бид авлаа. Тэгэхээр өнөөдөр шүүх шударга байх, шүүх бие даасан байх энэ асуудал Шүүхийн сахилгын хороо гэж энэ Үндсэн хуулийн байгууллагын цаашдын үйл ажиллагаа, цаашдын энэ байгууллагын ёс зүй, сахилга хариуцлага, дотоод итгэл үнэмшлээс ихээхэн зүйл шалтгаан уу гэдгийг энд хариуцлагатай хэлье. Монголын төр та бүгдэд энэ шүүхийн шударга байх, шүүх бие даасан байх энэ хариуцлагыг хүлээлгэсэн. Энэ хариуцлагын хүрээнд өнөөдөр ард түмэн Монголчууд шүүх бие даасан, шүүх хэрэг маргааныг зөв шийдэх шийдэл, шүүхэд

итгэх үнэмшлийн асуудал, шүүхийн сахилгын асуудал, ёс зүйн асуудал дээр бид өнөөдөр дүгнэлт хийж өнөөдөр тэр мафи болсон мафижсан систем байгаа шүү, шүүх дотор. Нуух юм бол байхгүй.

Тэр хонгилын шүүгч гэж байгаа. Тэр шүүх дээд шатны шүүгч нар ялангуяа Улсын дээд шүүхийн шүүгч нартай холбоотой энэ хэрэг маргааныг олон жилээр дараад, олон сараар ингээд дараад шийдэхгүй, аливаа асуудалд шударга бусаар хандаад байвал энэ байгууллага чинь цаашилаад энэ шүүх эрх мэдлийн асуудал байхгүй болно гэдэг ийм л байр суурьтай байгаа. Цаашилаад бид өнөөдөр энэ шинэ байгуулагдсан энэ байгууллагыг бас Монголын төр дэмжих ёстой. Бид нар төрийн хэмнэлтийн хууль гээд хууль батлаад тусгай чиг үүргийн байгууллагууд гээд тэнд бүх албан тушаалыг нь, хөрөнгө мөнгийг нь хуучин горимоороо ингээд явуулдаг харин хөрөнгө мөнгөөр дэмждэг албан тушаалын зэрэг дэвийг нь нэмдэг, орон тоог нь нэмдэг энэ үйл ажиллагаа бол энэ Үндсэн хуулийн бүтцийн байгууллага ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо гээд энэ байгууллагуудтай адилхан байх ёстой шүү. Энэ УИХ энэ дээр бас дүгнэлт хийх ёстой. УИХ-ын Тамгын газар гээд өнөөдөр тэргүүн дэд даргатай, дэд даргатай, 10, 20 зөвлөхтэй ийм байж байгаа шүү дээ. Гэтэл өнөөдрийн энэ байгууллагыг бид нар төрийн албаны ёс зүй, сахилга хариуц, ялангуяа энэ шүүх эрх мэдлийг бэхжүүлэх энэ үйл ажиллагааг явуулдаг энэ байгууллага бол тэр тусгай чиг үүргийн байгууллага дотор орж байж энэ шийдэгдэнэ. Энэ өнөөдөр бид нарт маш их хариуцлага ноогдуулсан энэ байгууллагын төрийн албан хаагчдыг ялангуяа энэ Үндсэн хуулийн бүтцийн байгууллагын шүүх эрх мэдлийн байгууллагын хүмүүсийн тэр цалин хангамж, нийгмийн баталгааны асуудлыг шийдэж байж бид тэд нартай хатуу хариулт ярих ёстой. Тэгэхгүйгээр бид өнөөдөр энэ шүүх бие даасан, шүүх хараат бус байх, шүүхийн эрх мэдлийн асуудал, шүүхийн сахилга харьцал,

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

зөрчлийн асуудал, шүүхийн итгэл үнэмшлийн асуудлыг бид нэлээн өөр байдлаар шийдэх ёстой л гэсэн ийм байр суурьтай байгаа.

Дээр нь өнөөдөр энэ давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхийн хэрэг маргааныг шийдэж байгаа энэ шийдлүүд олон өөр, олон янзаар дүгнэлт гарч энэ дээр хардалт бий болгодог. Энэ дээр Дээд шүүх тодорхой тайлбар ч гаргах ёстой. Дээр нь энэ шийдэгддэггүй байгаа, мафиин системээр, хуйвалдааны системээр байдаг ийм хардалтыг бий болгож байгаа асуудал дээр Шүүхийн сахилгын хорооны дэргэд энэ асуудлыг бас тодорхой хэмжээгээр авч ирж шийдүүлдэг ийм асуудлыг хуулийн хүрээнд, хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд шийдэхгүйгээр Дээд шүүх тэр бас I бид нарыг хянадаг бид нарын шийдвэрийг хардаг ийм асуудлыг энэ Шүүхийн сахилгын хорооны дэргэд байдаг юм шүү гэдгийг бас харуулж байж бас нөгөө талаар тэр гаргасан шүүхийн шийдвэрүүд өнөөдөр Үндсэн хуулийн хүрээнд бас үнэлэлт, дүгнэлт өгдөг байдлаар биш ч гэсэн тодорхой хэрэг зөрчлүүдийг, тодорхой онолын маргаантай энэ асуудлуудыг бас харж үздэг, шийддэг ийм бүтэц бий болгож байж бид нар өнөөдөр шүүх бие даасан, хараат бус байх энэ Үндсэн хуулийн зарчим чинь ард иргэдээс өнөөдөр яриад байгаа тэр шүүхийн тухай ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Сандаг-Очир гишүүн үгээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Шүүхэд шүүгч нарт гаргасан гомдлын тоо өмнөх онуудтай харьцуулахад эрс нэмэгдсэн. Тэрийгээ дагаад сахилгын шийтгэл оногдуулсан байдал нь тоо хэмжээ нь эрс нэмэгдсэн, 5 шүүгчид огцруулах арга хэмжээ авсан, 17 шүүгчид цалин бууруулах арга хэмжээ авсан, 17 шүүгчид сануулах арга хэмжээ авсан гээд ингээд байна. Тийм учраас энэ тоо өндөр байна гэдэг бол манай шүүхийн салбарт шүүгч

нарт сахилга батгүй байдал байна, өндөр байна гэдгийг харуулж байгаа тоо баримт л гэж үзэж байгаа юм. Тийм үү? Тэгээд та бүхэн бол зөвхөн ирсэн өргөдөл гомдлын дагуу хянаж үздэг, шийтгэл оногдуулдаг ийм.

Нөгөө талаар сая ярьж байна. Мэргэжлийн алдааг, ёс зүйн алдаа зөрчлийг манай эрхлэх асуудалд бол хүрээнд байхгүй ээ гээд. Тийм учраас цаашидаа бас энэ сахилгын хороо ёс зүйтэй холбоотой асуудлыг нь ингээд тусад нь, мэргэжлийн холбоотой асуудлыг нь тусад нь эд нар чинь ингээд бүгд хоорондоо уялдаа холбоотой л юм шиг надад санагдаж байгаа юм. Энэ сахилгын асуудал чинь ёс зүйтэйгээ холбоотой шүү дээ. Тэгээд ингээд ингээд тус тусад нь ингээд ялгаад салгаад ингээд энэ бол манай асуудалд хамаарахгүй энэ нь бол хамаарч байна гээд ингээд үзэхээр чинь бас л нөгөө шүүхийн шинэчлэлтэйгээ холбогдуулж шүүгчдийн ур чадварын асуудал, хараат бус бие даасан байх асуудал эд нар гэдэг чинь бас л нэгдсэн байдлаар асуудалд хандахад учир дутагдалтай л байна гэж харж байгаа юм.

Тийм учраас цаашидаа бол бас энэ сахилгын хороо бас энэ ёс зүйн асуудал болоод мэргэжлийн алдаа дутагдлын асуудлыг бол бас энэ шүүгч нарын гаргаж байгаа алдаа дутагдал нэгдсэн байдлаар энэ асуудлыг авч үздэг, шийддэг, хариуцлагаа оногдуулдаг байх ийм байдлаар бас авч үзэх ёстой юм биш үү. Байнгын хорооны дарга бас үүн дээр ямар бодолтой байдаг юм? Бид нарын баталсан хууль бас ингээд өнөөдөр мөрдөгдөөд эхэлчихсэн байна. Алдаа, сул тал гэдэг юм уу зөрчил дутагдалтай талууд нь бас ингээд ялгараад ус тосоороо ялгараад харагдаж байх ёстой юм байна. Тийм учраас бас бид нарын баталсан хуулийн I сул тал нь энэ байгаа юм биш үү? Цаашидаа бас амьдрал бас ийм асуудал гарч байгаа учраас үүнийгээ цаашидаа засаж залруулж бас хаанаа байх нь зүйтэй юм бэ гэдэг асуудал бас яригдах

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ийм хэрэгцээ шаардлага байгаа юм байна гэж би бол харж байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүн үгээ хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр шүүгч нарын хувьд бол мэдээж нийгэмд маш их тийм талцал хуваагдлыг авчирдаг. Шүүгч нарын шийдээж байгаа хэргүүд нь 1 хэрэг, 1 асуудал дээр 2 өөр, 3 өөр байр сууриар ханддаг. Албан тушаалтан болон жирийн иргэнд ялгамжтай ханддаг. Тэгээд дээрээс нь сүүлийн үед бол улс төрийн захиалгууд өөрөөр хэлбэл орон нутагт дэвших магадлал бүхий, Их Хуралд нэр дэвших магадлал бүхий тэр хүмүүсийг тодорхой хэмжээгээр тийм “Бүгд найрамдах” уншаад тэгээд дэвших эрхийг нь хасдаг. Ийм тохиолдлууд бол энэ улс төрчдийн захиалгаар маш их явж байгаа. Нийгэмд бол шүүгч нарт хандаж байгаа хандлага бол маш сөрөг байгаа. Тэгэхээр үүнийг засах, мэдээж яах вэ дээ. Энэ аливаа хэрэг маргаан шийдэгдэж байхад 1 нь шүүх дээр ялж байхад нь нөгөөдөх нь гомдож байдаг тийм гомдол бол үеийн үед нийгэмд байна. Тэр ойлгомжтой. тэгэхдээ яг 1 кэйс дээр өөр өөр шийдвэр гаргаад байгаа нь л хамгийн гол асуудлыг авчраад байгаа юм. Тийм учраас энэ шүүхийн хэрэг маргаан шийдвэрлэх энэ явц дээр бас яг энэ сахилгын хороо бас тодорхой дүгнэлт хийж, энэ дээрээ арга хэмжээ бас 1 шүүгч 1 төрлийн маргаан дээр 2 өөрөөр шийдвэр гаргаж байгаа, 3 өөр шийдвэр гаргаж байгаа тэрийг бас татаж хянах ийм шаардлага сахилгын хороонд бас гарах ёстой шүү. Зөвхөн ард иргэдээс ирж байгаа тэр гомдлоор шалгах биш та бүхэн бас яг энэ 1 асуудал дээр даргын талд шийдвэр гаргадаг, нөгөө 1 асуудал дээр яг тэр адилхан маргаанаар иргэний талд гомдолтой шийддэг ийм байдлыг л халах нь бас та бүхний хувьд бол хамгийн чухал асуудал байгаа.

Тэгэхээр яах вэ, энэ тайлангийн хувьд бол би энэ статистик тоонд бол дээрээс нь өнгөрсөн 1 жилийн хугацаанд

ажилласан энэ байдалд чинь би сэтгэл хангалуун байна. Яагаад гэвэл өнгөрсөн оныхоос 70%-аар ерөнхийдөө бол энэ сахилгын шийтгэл оногдуулалт бол нэмэгдсэн байна. 2015-2021 он хүртэл нийтдээ 7 жилийн хугацаанд 9 хүнд сануулах арга хэмжээ авч байсан бол өнгөрсөн жил гэхэд л 13-ыг оногдуулсан байна. Огируулах асуудлыг ерөөсөө 7 жилийн туршид хоёрхон хүнд оногдуулж байсан бол өнгөрсөн жил 3-ыг оногдуулсан. Тэгэхээр тэгээд нийтдээ сахилгын шийтгэл ноогдуулсан 7 жилийн хугацаанд 17 сахилгын шийтгэл ноогдуулж байсан бол өнгөрсөн жил 28 болж маш их өссөн байна. Тэгэхээр энэ бол мэдээж энэ шүүгчдэд бас тодорхой дохио өгч байгаа. Тэднийг бас энэ хэрэг шүүхдээ янз янзын авлига, хээл хахуулиас ангид байлгах тэгээд дарга нарт 1, жирийн иргэнд 1 өөр шийдвэр гаргадаг энэ явдлыг бас тодорхой хэмжээгээр хазаарласан. Өөрөөр хэлбэл бас 1 тийм, бид нар бас 1 ийм юу ч шийддэггүй хэсэг явж байсан бол одоо энэ байгууллага байгуулагдсанаар илүү шүүгч нар асуудалд голоор нь хандах ийм юм руу л ерөнхийдөө явах ийм ч боломжийг гаргаж өгсөн байна. Тийм учраас өнгөрсөн жилийн энэ сахилгын хорооны хийсэн ажилд бас сөрөг хүчний хувьд бол бас сайн үнэлэлт өгч байна.

Тэгээд энэ Үндсэн хуульд шинээр тусгагдаж, 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр энэ байгууллага байгуулагдаж тэгээд хамгийн болохгүй байгаа тэр иргэдийн итгэл муудсан, хамгийн тэр болохгүй байгаа тэр шүүх салбарт тодорхой сахилга хариуцлагыг бас 1 тийм, дээрээ хянадаг байгууллагатай гэдэг тийм нөхцөл байдлыг бий болгож байгаа танай байгууллагад амжилт хүсье. Тэгээд энэ эрчээ битгий алдаарай гэж хэлье. Баярлалаа.

Б.Энхбаяр: Миний хувьд бас Их Хурлын гишүүнийхээ хувьд бас хэдэн зүйлийг хэлье ээ гэж бодож байна. Гишүүд бас хандаж байр сууриа

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

илэрхийлээч ээ гэсэн асуудлыг бас тавьж байна.

Нөгөө талаар бас шүүхийн хуулийн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан хүний хувьд бол шүүхийн хуулийн хэрэгжилт ямар байгаа вэ гэдэг дээр үргэлж санаа чилээж харж явдаг. Өнөөдөр бол Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллага болсон, 2019 оны өөрчлөлтөөр ч цоо шинээр байгуулагдсан Шүүхийн сахилгын хорооны тайланг бид сонслоо.

Тэгэхээр хэд хэдэн зүйл бас байна. Сая Пүрэвдорж гишүүн их тодорхой хэлж байна. Ер нь энэ сахилгын хороог яагаад ингэж Үндсэн хуульд бүр ингэж биеийг нь даалгаж байгуулах болсон юм бэ? Шүүхэд итгэх иргэдийн итгэл их сул байна, хараат бус нөлөөнд орсон ийм байдал байна гэдэг ийм иргэдийн бодол санаа их түгээмэл болж байна, байсан. Тийм учраас энэ шүүхэд итгэх иргэдийн итгэлийг сэргээх нь өөрөө бас 1 зорилго нь байсан.

Шүүхийн сахилгын хорооноос тарааж өгсөн сая энэ статистик дээр бид их тодорхой харж байна. 22 оныг оруулахгүйгээр 21 он хүртэл 7 жилийн хугацаанд, 7 жилийн хугацаанд нийтдээ 17 шүүгчид сахилгын арга хэмжээ авч байсан юм байна. Хүчин төгөлдөр болж. Шүүхийн сахилгын хороо байгуулагдаж ажилласан өнгөрсөн онд гэхэд нийтдээ 28 шүүгчид арга хэмжээ авагдсан байна. Сахилгын шийтгэл хүчин төгөлдөр болсон байна. Энэ тоон статистик зүгээр юу хэлж байна вэ гэхээр 1 талаас харахад бараг ингээд бүтэн сүүлийн 10 жилийн хугацаанд л шүүгчдэд сахилгын шийтгэл ноогдуулж байсантай дүйх шийтгэлийг шинээр байгуулагдсан Сахилгын хороо 1 жилийн дотор ийм том хэмжээний шийтгэл ноогдуулсан. Ер нь хариуцлага сахилга батыг бол шүүгчдэд нэлээн, энэ чинь хэдэн зуу дахин статистик өсчхөөд байна шүү дээ, энэ чинь, ийм том хэмжээнд хариуцлагатай болж шийтгэл

ноогдуулдаг болж ирж байгаа юм байна шүү гэдэг нэгдүгээрт, сайн дохио.

Нөгөө талаар бол бид ганцхан тоогоор бас үнэлж болохгүй. Ер нь тоо бүр 0 байвал уг нь бол бидний мөрөөдөл. Өөрөөр хэлбэл огт сахилгын зөрчил гаргадаггүй шүүгч нартай, тэнд хариуцлага хүлээдэг ийм шийтгэл байдаггүй ийм тийм сайн цаг бол бидний мөрөөдөл гэдгийг бол бас цохож хэлж байгаа. Тийм учраас тоон статистикаар ганцхан мэдээж Сахилгын хорооны ажлыг бол бас мэдээж дүгнэж болохгүй. Энэ тоо улам багасдаг байгаасай, сахилга галздаггүй ийм шүүгч нартай болоосой гэсэн ийм л нийгмийг хүсэж байгаа. Тийм ч учраас хариуцлага тооцдог институц нь ингэж бие даалгасны бас үр дүн гарч ажиллажээ гэдэг нь харагдаж байна.

Сая бас хэлэлцүүлгийн шатанд гишүүдийн бас хөндсөн хэд хэдэн асуудал дээр би байр суурь илэрхийлье гэж бодож байна. Нэгдүгээрт, төрийн албаны ёс зүйн хууль гарч байгаатай холбоотой. Энэ хууль шүүхийн ч нарт бас үйлчлэгч юм шиг улам чангарах юм шиг буюу шинээр гарах төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг Шүүхийн сахилгын хороо барьж шүүгч нарт хариуцлага тооцох юм шиг агуулга хөндөгдсөн учраас би тухайлан тайлбар хийх шаардлага үүслээ.

Шүүгчид Монгол Улсын шүүгчид сахилгын шийтгэл ноогдуулах асуудал ганцхан шүүхийн хуулиар л зохицуулагдана. Энэ бол өөрөө шүүхийн хуульд нь байгаа. Ёс зүйн хуулиа эшилж шүүгчид сахилгын хэрэг үүсгэх болон сахилгын шийтгэл ноогдуулах асуудал байхгүй. Яагаад ингэсэн гэхээр түрүүн бас асуултад гарч байна. Жишээлбэл, тэр ёс зүйн хуульд бол биеэ аятайхан авч явах, формоо зөв өмсгөх, эд нар гээд бүр наад захын биеэ авч явах байдлын хэм хэмжээнүүд хуульчлагдаж байгаа. Хэрвээ та бүхэнд магадгүй энэ шүүгч энэ хувцсаа аятайхан өмсөөгүй байна, биеэ 1 арай жоохон зохисгүй авч яваад байна гэдэг ямар нэгэн хэмжүүргүй хүн хүнд өөрөөр

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тайлбарлагдах ийм хэм хэмжээгээр шүүгч хүнд хариуцлага тооцох эрхийг олгох юм бол энэ бол шүүгч нар эрх мэдлийн хувьд та бүхэн бол дахиад 1 хонгил болж хувирна. Шүүгч нарыг бол өөрийн бүрэн хараат байдалд оруулах эрсдэлтэй гэж үзсэн. Тийм учраас бид Европын загвар тэр дотроо Италийн загвар болох шүүгчдэд зөвхөн шүүхийн хуульд заасан үндэслэлээр л хариуцлага тооцдог тэр загварыг авсан байгаа юм. Энэ нь юутай холбоотой байсан бэ гэхээр тэр том томоохон зохион байгуулалттай гэмт бүлэглэл, мафитай тэмцэж байгаа шүүгчдийн амь насанд халдах, тэд нарыг ялих ялихгүй юмаар огцруулах, чөлөөлөх ийм нөлөөлөл мафикийнхаа зүгээс гараад байсан учраас тийм томоохон бүлэглэл гэмт хэрэгтэй тэмцэж байгаа шүүгч нараа хамгаалахын тулд үзэмжээр тайлбарлагдах эш үндэслэлээр шүүгчид хариуцлага тооцож болохгүй. Зөвхөн хуульд нэн тодорхой заасан үндэслэлээр л шүүгчид хариуцлага тооцно гэж шүүх эрх мэдлээ хамгаалсан заалтууд юм.

Яг үүний утгаар сая бас гишүүд хөндсөн. Мөн Шүүхийн сахилгын хорооны 3 гишүүн бас байр сууриа илэрхийлсэн. Шүүхийн мэргэжлийн алдааг Шүүхийн сахилгын хороо хянадаг байх эсэх, асуудал шүүхийн хуульд яригдаж энэ түрүүн хэлсэн 3 үндэслэлээр л Шүүхийн сахилгын хороо хянахаас мэргэжлийн алдаагаар дамжуулж гэдгээр дамжуулж шүүхийн шийдвэрт нөлөөлдөг, чиглэл өгдөг, шүүгч нарт ингэж шийдэхгүй бол чам дээр хэрэг үүсгэнэ шүү гэж албан болон албан бусаар дарамталдаг нөлөөндөө оруулдаг ийм байдал хавтгайрсан байсан учраас хуульд нь нэн тодорхой зааж 1 талаас шүүх эрх мэдлээ хамгаалсан заалтуудыг, нөгөө талаасаа Шүүхийн сахилгын хороо нь Үндсэн хууль ёсоор шүүгч болон шүүгч бус бүрэлдэхүүнээс бүрддэг. Сая бол шүүгч бус буюу парламентаас томилогдсон төлөөлөл мэргэжлийн алдааг хянадаг байя гэдэг асуудлуудыг тавьж байгаа. Шүүгч бол мэргэжлсэн, мөн шалгалт өгсөн, тогтвортой ажилласан

ийм бас системтэй. Тухайлбал Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр шүүн таслах үйл ажиллагаанд 10 жил ажиллаад, алдаа дутагдал гаргаагүй хүн Дээд шүүхийн шүүгчээр томилогдох хууль зүйн шалгууртай. Ийм хүний шүүхийн шийдвэрийг мэргэжлийн алдаа мөн эсэх асуудлыг Сахилгын хороо буюу шүүгчээр ажиллаж байгаагүй хүмүүс хянана гэж байхгүй. Хэрвээ шүүхийн шийдвэрийн хууль зүйн зөв үндэстэй эсэх асуудал шүүх хэрэглээг зөв хэрэглэж байгаа асуудлыг бид хэрэглэх гэж байгаа бол шүүхийн дээд байгууллага болох Монгол Улсын Дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг шүүх системдээ хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа юм.

Хэрвээ бид Сахилгын хороонд мэргэжлийн алдааг шалгах байдлаар шүүн таслах ажиллагаанд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг өгөх юм бол энэ маань нөгөө талаар дахиад Үндсэн хуулийн зөрчил болж, Улсын Дээд шүүхийн шийдвэрүүдийг Шүүхийн сахилгын хороо хянаж эхэлнэ гэсэн үг. Дээд шүүхийн шүүгчдийн шийдвэрийг мэргэжлийн алдаа мөн эсэх байдлаар цаад утгаараа шийдвэр лүү нь ороод эхэлнэ гэсэн үг. Ингээд эхэлбэл бидний Үндсэн хуультай ёсны нөгөө Улсын Дээд шүүхийн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах энэ шийдвэр лүү шүүн таслах ажиллагаа явуулж байгаагүй, ажлын туршилагатай олонх нь бүрдсэн Сахилгын хороо орох нигуур байсан учраас Шүүхийн хуульд энэ асуудлыг маш олон талаас нь ярьж саяын зохицуулалтыг хийсэн байгаа гэдгийг би олон удаа яригдсан учраас зориуд тайлбар хийе.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Шүүхийн сахилгын хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Баярлалаа.

12.36 цаг

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дараагийн асуудалдаа оръё.

“Монгол УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард ХЗБХ-ны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Байнгын хороон дарга аа, цаглавартай холбогдуулаад 1 асуух л зүйл байна. Юу гэвэл Утааны тухай сонсгол 4 сарын 2 дугаар хагастаа багтаад хийе ээ гэдэг асуудал ярьсан. Өнөөдөр 4 сарын 18 болчихсон байгаад байна. Тэгээд энэ дээр ямар нэгэн шийд юм гарч байна уу, дарга аа. Энэ дээр та 1 хариу өгөөч. Үүнийг үнэхээр бид нар авч хэлэлцэж ярихгүй юм бол энэ чинь эргээд энэ иргэдийн амьдрал, эрүүл ахуй, нөгөө эрүүл амьдрах эрх, тэр хүний суурь эрх бид нарын бүх яриад байгаа юмнуудын чинь хамгийн гол зангилаа. Ялангуяа Улаанбаатар хотын иргэд. Ер нь утааны асуудал нэгэнт ярьж байгаа юм чинь энэ чинь энэ төв суурин газруудад бүгдэд нь байж байгаа зүйл болохоор зөвхөн Улаанбаатарын бас асуудал биш болчихоод байгаа юм. Тэгээд үүн дээр 1 энэ сонсголоо хийж ярихгүй юм уу? Үүн дээр та 1 хариулт өгөөч.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн нийслэл Улаанбаатар хотын утааны бохирдолтой холбоотой асуудлаар бас Хүний эрхийн дэд хороон дээр нээлттэй сонсгол хийх саналыг удаа дараа гаргаж байгаа. Энэ саналыг бол Байнгын хорооны даргын хувьд бол дэмжиж байгаа. Хүний эрхийн дэд хорооны дарга Мөнхцэцэг гишүүнд энэ асуудлаар би бас тухайлан 2 удаа уулзсан. Нээлттэй сонсгол хэлбэрээр энэ асуудлыг зохион байгуулах ёстой гэдэг ийм байр сууриа бас хэлсэн. Тэгэхээр Хүний эрхийн дэд хороон дээр ирэх 7

хоногийн хуралдааны хуваарьт ХЭҮК-ын тайланг хэлэлцэхээр байгаа. Энэ тайлантай холбоотойгоор бас тусдаа эрүүдэн шүүхийн комиссын гишүүний тайланг мөн тусдаа сонсгол хэлбэрээр хэлэлцэнэ. Нэлээн дэлгэрэнгүй ярья гэсэн бодолтой байгаа. Яг энэтэй хамт бас танаас дэвшүүлсэн энэ нийслэл Улаанбаатар хотын утааны холбогдсон энэ асуудлыг бас сонсгол хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгэхээр Мөнхцэцэг гишүүний чөлөөтэй байна. 4 дэх өдөр ирнэ, 4 дэх өдөр ирэхээр нь хэлэлцээд энэ асуудлыг бас ойрын үед бэлтгэлийг нь хангаад зохион байгуулах саналтай байна. Энэ дээр хамтарч ажиллая, тантай.

Асуух асуулттай гишүүд дууссан. Асуулт дууссан.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя.

“Монгол УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард ХЗБХ-ны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ Цогтбаатар гишүүн сая микрофон нь ажилласангүй. Таны. Цогтбаатар гишүүн горимын санал гаргах уу, та?

Д.Цогтбаатар: Би сая дэмжсэн санал өгсөн, миний машин ажилласангүй. Тэгэхээр энэ саяын саналыг хүчингүй болгож, юу санал хурааж өгөхгүй юу.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

58.3%-ийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоол батлагдлаа.

Энэ чинь сая одоо дахин санал хураалт явуулна. Дахин санал хураалт явуулъя.

63.6%-ийн саналаар тогтоол дэмжигдлээ.

12.41 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

ХЗБХ-ны 2022 оны 10 сарын 26-ны өдрийн 16 дугаар тогтоолоор Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус “тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Тогтоолын гишүүн холбогдуулж үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

63.6%-аар тогтоол батлагдлаа.

12.43 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

ХЗДХ-ийн сайдаас 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-ын гишүүн Одонтуяад ирүүлсэн асуултын хариуг сонсоно.

УИХ-ын гишүүн Одонтуяад ирүүлсэн асуултын хариуг ХЗДХ-ийн сайд Хишигээгийн Нямбаатар танилцуулна. Нямбаатар сайдын микрофоныг өгье.

Х.Нямбаатар: НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсэг 22 оны 10 дугаар сарын 03-наас 14-ний өдрийг дуустал хугацаанд Монгол Улсад ажиллаж, төрийн албан хаагч, шүүгч, прокурор, хуульч, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгчид болон бусад оролцогч талуудтай уулзаж, ярилцлага хийсэн байдаг. Тус ажлын хэсгээс дур зоргоор саатуулахаас хамгаалах эрхийг хангах тал дээр Монгол Улсын эрх зүйн орчин мэдэгдэхүйц сайжирсан. Цаашид уг эрхийг бататгах тал дээр зогсолтгүй урагшлах нь чухал талаар дүгнэж, 23 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хэвлэлийн хурал хийсэн байна. Уг дүгнэлт, мэдээлэлд Монгол Улсын ЗГ-аас олон шинэчлэл хийсэн боловч шүүхийн шийдвэргүйгээр цагдан хорих асуудал онцгой тохиолдол гэхээсээ илүү жирийн үзэгдэл хэвээр байгаа. Иргэдийг цагдаагийн байгууллагад хуульч байлцуулахгүйгээр байцаалт авдаг байдал хэвшмэл болсон. Мөрдөгч прокурор асар их хяналтгүй эрх мэдэл эдэлж байхад талуудын тэгш байдлыг үл тоомсорлон шүүгчдэд зохих эрх зүйн бүхий л баталгааг хангаж өгөхгүй байгаа. Мөн дагнасан шүүх байхгүй, шүүхийн боловсон хүчний хомсдол, ажлын хэт их ачаалал зэргээс үүдэн шүүхийн тогтолцоо асар их дарамтад орж байгааг шинжээчид онцолсон.

Түүнчлэн ковид 19-ийн тахалтай тэмцэхэд хэрэглэж байсан хуулийн зохицуулалтыг оновчтой бус тайлбарласнаас эсхүл томъёолол нь тодорхой бус байснаас хүний эрх хамгаалагчдын хууль ёсны ажилд саад

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

болох, тайван замаар үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан эвлэлдэн нэгдэх, эрх чөлөөг хязгаарлахад ашиглагдаж болзошгүй байгаа талаар дүгнэсэн байдаг.

Дээрх ажлын хэсгийн гаргасан мэдээлэлтэй холбоотойгоор Монгол УИХ-ын гишүүн Салдангийн Одонтуяагаас ХЗДХЯ-нд ирүүлсэн асуултын тайлбарыг дараах байдлаар танилцуулж байна.

1. ЭХХШТХ-д сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй баривчлах зохицуулалтыг тусгайлан хуульчилсан. Хуульд тусгайлан заасан тохиолдлын дагуу прокурорын хяналт доор шүүхийн зөвшөөрөлгүй сэжигтнийг баривчилдаг. Тодруулбал ЭХХШТХ-ийн 31, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар нэгдүгээрт, сэжигтнийг гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан, хоёрдугаарт, хуульд заасан хойшлуулиггүй тохиолдолд, гуравдугаарт, гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан, дөрөвдүгээрт, тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн үл мөр илэрсэн зэрэг эдгээр 4 тохиолдолд мөрдөгч сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилдаг.

Харин хойшлуулиггүй тохиолдлыг хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн үл мөр, эд мөрийн баримтыг устгах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа тохиолдлыг ойлгохоор хуульд тодорхойлсон.

2021 онд шүүхийн шийдвэргүй баривчилсан сэжигтний 14.3%-ийг гэмт хэрэг үйлдэж байх үед эсхүл тэр дор нь барьсан, 9.4%-ийг тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн үл мөр илэрсэн тохиолдолд, 29%-ийг гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч хохирогч шууд заасан тохиолдолд, 47.3%-ийг хуульд заасан

хойшлуулиггүй тохиолдолд баривчилсан бол мөн нийт 58132 хэрэг шалгаж хойшлуулиггүй тохиолдолд 908 сэжигтнийг баривчилснаас 878 сэжигтнийг тэр дээрх дээр дурдсан үндэслэлээр шүүхийн шийдвэргүйгээр баривчилсан байна.

Хүний эрх, эрх чөлөөг хангаж мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийг 1 мөр хэрэгжүүлэх зорилгын хүрээнд дээрх сэжигтнийг шүүхийн шийдвэргүйгээр баривчлах ажиллагаа нь 24 цагийн прокурорын хяналт дор явагддаг. Харин хууль бусаар баривчилсан бол прокурор нэн даруй суллахаар хуульд заасан.

2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, төрийн албаны тухай хууль, ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмыг баримтлан, албан хаагчдад ажлын үр дүнг дүгнэн, хууль тогтоомжид заасан урамшуулал олгодог бөгөөд сэжигтэн яллагдагчийг олноор нь баривчилсан, цагдан хорьсон нь мөрдөгчийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлт болон цалингийн урамшуулал олгох үндэслэл болдоггүй.

3. ХЗДХЯ-наас санаачлан боловсруулж УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-аас буцаасан ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээг авахад практикт амралтын өдрүүдэд тохиоход шүүхээр шийдвэрлүүлэхэд хүндрэл үүсэж, үүнээс улбаатай ялангуяа сэжигтнийг баривчлах хугацаа хэтрэх тохиолдол гарч болзошгүй байгаатай холбогдуулан энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс шүүхийн зөвшөөрлийг амралтын болон бүх нийтийн амрах өдрүүдэд авч хэрэгжүүлэх тухай 24 цагийн шүүх ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан.

4. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэсэгт улс орны буюу тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, гамшиг болон аюул тохиосон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал цуглаан хийхийг хориглоно гэж, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт гудамж талбайд жагсаал цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлэхээр заасан.

Монгол Улсад 2020 онд 237, 2021 онд 178 удаагийн жагсаал цуглааныг иргэд олон нийтийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөгөө эдэлж, зохион байгуулж явуулсан бөгөөд цагдаагийн байгууллагаас ЗГ, УОК, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас гаргасан шийдвэрийн дагуу ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ард иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байх зөвлөмж, шийдвэр хуульд заасан үүргийн хүрээнд уул ажиллагааг болон оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах олон нийтийн хэв журмыг хамгаалах ажиллагааг явуулсан. Т

5. Дур зоргоор баривчлах саатуулах асуудал хариуцсан ажлын хэсэг нь эцсийн дүгнэлтээ 2023 оны 9 дүгээр сард гаргаж, НҮБ-ын ХЭЗ-д танилцуулах бөгөөд тус яамнаас 22 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр ГХЯ-нд Ажлын хэсгийн дүгнэлт, тайлангийн төсөлд өгөх хариу тайлбар, тодруулгын эцсийн тайлан дүгнэлтэд тусгуулахаар хүргүүлсэн болохыг энд дурдах нь зүйтэй. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Энхбаяр: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж, хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Батзэвэгийн Энхболд ХЭҮК-ын гишүүн, Максимын Чинбат Монгол УЕП-ын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх, Пүрэвжавын Сайнзориг ХЗДХЯ-ны ТНБД, Дорждэрэмийн Цолмон ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга,

Батчулууны Баярхүү УЕПГ-ын хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор, Хууль цаазын шадар зөвлөх, Ганболдын Ганбат ХЭҮК-ын референт, Нармандахын Жамъянхүү ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Баттөмөрийн Батсуурь Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа, Идэрийн Батчулуун ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Болд-Эрдэнийн Ганзориг ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан УИХ-ын гишүүн Одонтуяагийн асуулттай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Одонтуяа гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ХЗБХ, УИХ миний өргөн барьсан Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, хэлэлцэх эсэхийг нь шийдсэн байгаа. Тэгэхээр үүний анхны хэлэлцүүлгийг нь Байнгын хорооны дарга аа, ерөөсөө явахгүй байгаа. Хэрвээ энэ хууль яаж байгаа вэ гэхээр өөрөөр хэлбэл энэ шүүхийн шийдвэргүй баривчилж байгаа асуудлын чинь ихэнх нь энэ хуулийн дагуу яваад байгаа юм. Өөрөөр хэлбэл өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр хүндэд халдсан гэж үзээд 1 албан тушаалтан 1 иргэнийг цагдаад өгдөг, цагдаа 50000-аар торгодог, дараа нь 500000-аар торгодог, тэгээд 3 дахь удаагаа явбал шууд баривчлаад явчаж байгаа юм. Тэгээд энэ бол ерөөсөө өнөөдрийн энэ нөгөө Үндсэн хуулиар олгогдсон тэр эрх, эрх чөлөөг боомилж байгаа маш том ухралт болчихоод байгаа. Тийм учраас энэ хуулийг хэлэлцэх юм бол, энэ хуулиар чинь 2021 онд нийтдээ 292 хүнийг торгочихсон байгаа, 20 онд 292, 2021 онд 350 хүнийг торгочихсон. 22 оны тайлан гараагүй байгаа. Тэгээд энэ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хүмүүс ингээд торгоод, 1 жил нь торгочхоод дараа жил нь ингээд баривчлаад ингээд яваад байгаа нь энэ шүүхийн шийдвэргүй баривчилж байгаа энэ асуудалтай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл энэ чинь прокурорын хяналтгүй яваад байгаа байхгүй юу. Тийм учраас энэ дээр тодорхой энэ хуулийг хэлэлцүүлэх анхны хэлэлцүүлгийг нь яаралтай Байнгын хорооны дарга аа, хиймээр байна. Тэгэх юм бол энэ Одонтуяа гишүүний гаргаж тавиад байгаа энэ шүүхийн шийдвэргүй баривчлаад байгаа энэ асуудал чинь миний энэ хуультайгаа холбоотойгоор бас 30-аад хувь нь багасах ийм боломжийг авчирч байгаа.

Тэгэхээр яг энэ асуудлаар энэ шүүхийн шийдвэргүй баривчилж байгаа энэ асуудал дээр яг энэ гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу хэдэн хувь нь шүүхийн шийдвэргүй баривчлагдаад байгаа юм бэ. Яг энэ хуулийг зөрчсөн гээд Зөрчлийн хуулийн 59-өөр торгоод, дахин торгоод тэгээд баривчлаад байгаа энэ статистик нь хэдэн хувьдаа байгаа юм бэ. Өөрөөр хэлбэл 2021 онд 350 хүнийг торгосон байна шүү дээ. Дарга нарыг, дарга нар гомдоод тэр хүмүүсийг торгосон байна. Энэ шүүхийн шийдвэргүйгээр баривчлах энэ зүйл бол хүний эрхийн асар том ухралт. Тэгэхээр жил болгон очоод Нью-Йоркт очиж хүний эрхийн тэр комисс дээр бас тайлан илтгэлээ тавьдаг ... /минут дуусав/

Б.Энхбаяр: УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн III дүгээр зүйлийн III-ийн 1-ийн 2-т Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асууна гэж заасан байна.

Тийм учраас асуулт хариултын хугацаа 3 минут байгаа юм байна шүү гэдгийг гишүүддээ сануулъя.

Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Бид нар 1 яг гишүүд 1 зүйл дээр хэдүүлээ тогтсон 1 ойлголт авъя. Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Цагдаагийн байгууллагын тухай хуульд.

Саатуулах гэж 1 ойлголт байгаа юм. Баривчлах гэж 1 ойлголт байгаа юм. Цагдан хорих гэсэн ойлголт байгаа юм. Цагдаагийн байгууллага тэр сэжигтэй этгээдийн хэн болохыг тогтоогоод 6 цаг хүртэл өөрийнхөө оффист байлгаад тодруулж болно. Үүнээс хойш 24 цагийн дотор прокурорын зөвшөөрөл авч, тухайн этгээдийг баривчилж, цаашид хэргийн тэр үйл баримтыг бэхжүүлэх, ул мөрийг баллахаас урьдчилан сэргийлэх ажиллагаа хийх үү, үгүй юү гэдгийг хийдэг. Ингэхдээ 4 тохиолдолд шүүхийн шийдвэргүйгээр энэ 48 цагийн хугацаанд баривчлах энэ процесс прокурорын хяналт доор явагдана. Түрүүн би хэллээ.

1 дүгээрт, яг тухайн гэмт этгээдийг гэмт үйлдлээ үйлдэж байхад нь тэр дор нь, 2-т нь, хуульд заасан хойшлуулигүй ажиллагаа явуулах тохиолдолд, 3 дахь нь, гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч хохирогч шууд нөгөө этгээдийг гэрчилсэн тохиолдолд, 4 дүгээрт нь, тухайн хүний хувцас, тэр орон байр, машин тэрэгнээс нь гэмт хэргийн ул, эд мөрийн баримтууд олдсон тохиолдолд ийм 4 тохиолдолд тухайн хүнийг прокурорын хяналт доор шүүхийн зөвшөөрөлгүйгээр 48 хүртэл цагаар баривчлах процесс явж байгаа.

48-аас хойш бол ямар нэгэн шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах, хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах ойлголт байхгүй. Энэ нь таслан сэргийлэх арга хэмжээ буюу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ байгаа. Би түрүүн хувиудыг нь хэлсэн. Хойшлуулигүй гээд юуг хэлээд байна вэ гэвэл хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, ялагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд баримтыг устгах, зөвшөөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх ийм бодитой аюул байгаа тохиолдол гэсэн энэ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үндэслэлээр хойшлуулиггүй гэж үзэж байгаа юм.

Өнгөрсөн оны статистикийг хэлсэн. Шүүхийн шийдвэргүй сэжигтнийг баривчилсан 14%-ийг гэмт хэрэг үйлдэж байхад нь, эс үгүй бол тэр дор нь үйлдсэнийх нь дараа, 9.4% нь тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэл, гэмт хэрэгт нь үйлдсэн ул мөр нь илэрсэн, 29%-ийг нь гэрч, хохирогч шууд заасан, 47%-ийг нь хойшлуулиггүй гэсэн ийм хувь хэмжээтэйгээр 48 цагийн хугацаатай баривчилсан байна.

Ингэхдээ прокурорын хяналт доор авсан байна. Ингээд шүүхэд үргэлжлүүлж хорих тохиолдолд заавал шүүхэд хандсан. Бид нар 72 цагийн хугацаатай баривчилдаг байсан явдлыг өнгөрсөн 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлж хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн хуулиар 48 цаг болгосон. Одоо бид нар шинээр дахиад төсөл өргөн барих гэж байгаа нь энэ баяр ёслолын өдрүүд, амралтын өдрүүдэд шүүхийн зөвшөөрөл өгдөг жижүүрийн шүүгч ажиллуулдаг зохицуулалтыг оруулж ирэх гэж байгаа юм.

Б.Энхбаяр: Нэмэлт 1 минут гэдэг дэг асуулт дээр байдаггүй юм байна. Ажлын хэсгээс нэмж хариулах уу? 4 номерын микрофон Сайнзориг дарга хариулъя.

П.Сайнзориг: Пүрэвдорж гишүүний асуултад нэмж хариулъя. Ерөнхийдөө зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг бас хуулийн хүрээнд явуулж байгаа. Өөрөө цагдаагаас юу гэдэг юм баривчлах шийтгэлийг гэдэг юм уу үзэл бодлоо илэрхийлэх явц буюу жагсаал цуглааны хувьд хүний нэр төрд халдсан гэдэг үндэслэлээр та бас асуудлыг хөндөж тавьсан. Энэ үед үндсэндээ энэ баривчлах шийтгэлийг зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулаад шүүхэд оруулж шүүхээс шийдэж байгаа юм. Хэрэв баривчлах шийтгэл

оногдуулахаар бол. Гол төлөв үндсэндээ торгох ялыг л оногдуулж байгаа.

2 дугаарт, нийт баривчлах шийтгэл буюу шүүхээр ороод шийтгэгдэж байгаа энэ шийтгэл маань зөрчлийн оногдуулж байгаа шийтгэлийнхээ 0.7%-ийг л эзэлж байгаа, 0.7%. Тэгээд зөрчлийн шийтгэлийн шүү дээ, 0.7

2 дугаарт, яг Пүрэвдорж гишүүний ярьж байгаа энэ асуудлыг бид хэт ерөнхий байгааг бас залруулах үүднээс Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг ЗГ-аас өргөн барихдаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол торгож байгаа энэ явдлыг халаад маш тодорхой бичсэн. Таны ярьж байгаа тэр асуудлуудыг бүгдийг нь хуулийн төслөөс хасаж бас тантай ижил концепцоор бас ЗГ хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа. Үүнийг хэлэлцүүлээд явахад таны ярьж байгаа зүйлүүд бас арилах юм гэдэг зүйлийг хэлье.

Дээрээс нь сая Нямбаатар сайд хэлсэн. Ер нь 48 цаг баривчлаад прокурорын хяналттайгаар баривчлаад шүүх рүү орж цагдан хорих уу эсвэл цаашаа үргэлжлүүлэн суллах уу гэдэг асуудлыг шийддэг. Энэ дээр болон он оноороо бас бас тодорхой шүүхүүд дээр шийдвэрүүд гарч байгаа 57.9%-ийг бол үргэлжлүүлэн хорино гэсэн шийдвэр жишээ нь шүүх дээр гарч байсан байна. 21 онд 57.7%, энэ оны зүгээр 3 дугаар улирлын байдлаар 52%-тай ч юм уу ингээд зайлиггүй шүүхээс үргэлжлүүлж хорих шаардлагатай байна гэдэг ийм шийдвэрийг ингээд прокурор бас шүүх дээр хэлэлцүүлээд ингээд шийддэг гэсэн ийм статистик байдаг юм.

Б.Энхбаяр: 6 номерын микрофон. Мөрдөн байцаах албаны дарга, хурандаа Батсуурь хариулъя.

Хурандаа Батсуурь байна. Зөрчлийн тухай хуулийн 3-ын 5-д

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

баривчлах шийтгэлийг зөрчлөөс нь хамаарч саналаа шүүхэд хүргүүлж баривчлах асуудал шийдвэрлүүлдэг. Нямбаатар сайд түрүүн хариулсан нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5-ын 2-т зааснаар 6 цаг хүртэл хугацаагаар саатуулж, тэр хүний хэн болохыг нь тогтоодог. Зөрчлийн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжид заасны дагуу 6-гийн 2 ийн 3, 6-гийн 2-ын 9-д заасныг мөрдөгч шүүхийн шийдвэр баривчлах тухай саналаа прокурорт хүргүүлж, прокурор шүүхэд уламжилж, шүүхийн шийдвэргүй баривчлах асуудал шийдвэрлэгдэж явдаг хууль зүйн зохицуулалттай үндэслэлүүдийг сайд хэлсэн болно.

Б.Энхбаяр: Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Би зүгээр 1 үүнтэй яг энэ асуулттай биш холбоо, шууд холбоогүй. Дараагийн шатны 1 асуулт асуучихмаар байгаа. Энэ шүүхийн шийдвэрээр үргэлжлүүлэн хорих шийдвэр гарчихлаа. Тэгэхээр энэ дээр тэгж хоригдсон хүмүүсийн хэдэн хувь нь шүүхээр яваад буруутай нь тогтоогдсон байгаа вэ? Өөрөөр хэлбэл хэдэн хувь нь баахан хүнийг хорьж хорьчихоод хэдэн хувийн дараа нөгөө буруутай нь тогтоогдохгүй байна гээд гаргаж байгаа вэ. Энэ статистик бол надад илүү сонин санагдаад байна. Тэр яг НҮБ-ын гаргасан асуудлаас энэ арай тусдаа гэдгийг би ойлгож байгаа.

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Цогтоо сайдад маш чухал асуулт асуулаа. 48 дуусаад шүүх рүү үргэлжлүүлэн хорих тохиолдолд шүүх хурал хуралдаж байгаа юм. Энэ хүнийг хорих үндэслэл байгаа эсэх талаар улсын яллагч прокурор танилцуулаад хууль сахиулагчид мөн нэмэлт материалуудаа гаргаад ингээд хурал явж байгаа юм. Энэ тохиолдолд статистикийн хувьд энэ 48

баривчлагдсан үргэлжлүүлээд цаашаа 30 хоногоор цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан статистик хооронд зөрөө байгаа. Таны асууж байгаа бол бүр цагдан хоригдчихоод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ороцож 2, 3 жил яваад эцэст нь цагаатсан, эс үгүй бол ял гэм буруутайд тооцогдсон статистикийг гаргаж ирээч ээ гэж байх шиг байна. Үүнийг яг бид нар манайхан тэнд материал харж байгаа байх.

Ер нь бол Цогтоо сайд аа, ийм юм байгаа юм. Бид нар 1 ийм хуулийн техникийг сүүлийн бараг 30-аад жил маш бага ашиглаж байгаа. Манай дээр яг статистик нь төвлөрч явдаг. Тэр нь юу гэхээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлоо нөхөн барагдуулах журмыг ЭХХШТХ-д тусад нь бүлэг болгож зохицуулсан. Одоогоос бараг 33 жилийн өмнө буюу 4 сарын 20-доор 90 оны 4 сарын 20-нд яг энэ зохицуулалт анх удаа манай хууль тогтоомжийн бие даасан төрөл болж орж ирсэн. 1 нь болохоор төрийн захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан гэм хорыг арилгах журам. Нөгөөх нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, прокурор, шүүгчийн хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан гэм хорыг арилгах журам. Өөрөөр хэлбэл энэ журам механизм сайн ажиллаад ирэхийн хэрээр саяын ярьж байгаа хууль бусаар хорьдог, эрүүдэн шүүдэг, эс үгүй бол ажлын ур чадвар практик дутаж, хүнийг маш олон жил хэлмэгдүүлдэг энэ механизм өөрөө арилна. Одоогийн байгаа ЭХХШТХ дээр энэ процесс механизм маш тодорхой болж ирж байсан.

Дээр нь 1 зүйл нэмээд хэлэхэд энд орж ирж суусан уу, үгүй юү, ХЭҮК-т бие даасан эрүүдэн шүүлтийн эсрэг комиссарыг бид хэд томилсон. Өөрөөр хэлбэл омбудсменийн тогтолцоог бид нар ажиллуулдаг болгоё гээд сүүлд манай Их Хурлаас 1 хүнийг томилсон. Тэр механизм өөрөө шууд мөрдөгчийг шууд ажлыг нь

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

түдгэлзүүлэх саналыг холбогдох байгууллагад тавих хүртэл ийм эрхтэй омбудсменийн төлөөлөл бас ажиллаад 1 жил болж байгаа. Тэгэхээр бид нар бол энэ НҮБ-ын тайлан дээр бид нарыг Одонтуяа гишүүн үүнийг сайн уншсан байх, маш олон зүйлүүдээр бид нарыг дэвшил гарсан байна гэдгийг дүгнэсэн. Би тэгэхээр бас Одноо даргыг их туршлагатай парламент учраас сайныг нь сайн, мууг нь муу гэж ялгаж хэлэх байх гэж бодож байна.

Б.Энхбаяр: ХЭҮК-ын гишүүн Энхболд гишүүн бас энэ зарчмын Цогтбаатар гишүүний зарчмын асуултад бас нэмж хариулъя. 7 номерын микрофон.

Б.Энхболд: Цогтбаатар гишүүний асуултад зарчмын хувьд бас хариулт өгье. Ерөнхийдөө үргэлжлүүлж цагдан хоригдсон хүний хэдэн хувь нь ял авдаг вэ гэдгийг бас нарийвчлан судалгааны дүн бол бид гаргасангүй. Гэхдээ ер нь хорих ял шийтгүүлсэн нийт хүмүүсийн 24.3% нь шүүхийн өмнөх шатанд цагдан хоригддог гэдэг ийм судалгааг ХЭҮК гаргасан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл мөрдөн шалгах ажиллагааны мөрдөн байцаалтын шатанд 10 хүн тутмын 2 нь л цагдан хоригддог гэсэн ийм үзүүлэлтийг энэ олон улсын судалгааны байгууллагын дүгнэлтүүд, комиссын судалгаан дээр үндэслэж гаргасан байгаа

Б.Энхбаяр: Яах вэ, энэ нэлээн нарийн гардаг юм байна лээ, яах вэ. Хууль зүйн дэд сайдаар ажиллаж байх үед 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн хэрэгжилт бол 17 оны 7 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн байдаг. Үүнээс 1 жилийн дараа буюу 2018 оны 7 сарын 1-ний үед яг Цогтбаатар гишүүний асуусан цагдан хоригдсон хүмүүс цаашаа шүүхээр ял шийтгэгдсэн байдлыг шинэ хууль болон хуучин хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор харьцуулж авч үзэж, судалгаа гаргаж байсан. Тэр үед. Тэр үед гаргаж байсан судалгаагаар 2002 оны Эрүүгийн хуулиар цагдан хоригдож ял

шийтгэгдсэн байдлыг авч үзэхэд 5:1 гэдэг харьцаа гарч ирж байсан. Өөрөөр хэлбэл цагдан хоригдсон 5 хүн тутмын 1 нь ял шийтгэгдэж байсан байна буюу 5 хүний 4 нь шүүхээр ял шийтгэгдээгүй байсан гэдэг ийм судалгаа гарсан.

2017 оны 7 сарын 1-нээс хойш хэрэгжиж эхэлсэн шинэ Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-ийн нөлөөгөөр энэ тоо жилийн дотор 5:3 гэсэн ийм харьцаатай болсон байсан. Би одоогоос 5 жилийн өмнөх статистик яриад байгаа шүү, 18 оны 7 сарын 1-ний байдлаар авч үзэж байсан статистик ярьж байгаа юм. Өөрөөр хэлбэл цагдан хоригдсон 5 хүний 3 нь шүүхээр ял шийтгэгдсэн 1 талаасаа, нөгөө талаасаа цагдан хорих тоо нь өөрөө хэд дахин ч буурсан, бүр хэд дахин шүү буурсан гэдэг ийм статистик шинэ болон хуучин хуулийн зөрөөн дээр жилийн дараа хийсэн судалгаагаар бол гарч байсан гэдгийг тухайн үед бас энэ судалгааг хийх ажлын хэсгийг ахалж байсан хүний хувьд би бол танд бас нэмж хариулъя.

Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр энэ НҮБ-ын шинжээчдийн дүгнэлтийг энэ 23 оны 9 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 54 дүгээр чуулганд танилцуулна гэсэн байгаа юм л даа. Тийм учраас би бас Монгол Улсынхаа нэр хүндийг бодож байна. Энэ хооронд бид нар дутуу хийсэн ажлуудаа хийж хэрэгжүүлэх гээд ер нь энэ олон аливаа зүйлийг 1 Монголчлохгүйгээр, ухралт хийхгүйгээр энэ аль болохоор олон улсын гэрээ конвенцод ойртуулах энэ зүйлүүдийг л яриад байгаа юм. Яагаад гэхээр би бол өөрөө энэ цагаатгалын комиссын дарга учраас 1 зүйлд бүр ингээд сэтгэл маш их харамсдаг л даа. Энэ бол Монгол Улс тухайн үед ял өгч байсан хүмүүсийнхээ 80%-ийг нь цаазалчихсан байгаа байхгүй юу. Тэр чинь аймшигтай шүү дээ, энэ чинь. Гэтэл тэр Орос бусад оронд бол нэг 20%-тай. Гэтэл яагаад Монголд 80% цаазлуулчихсан байгаа юм, энэ чинь өөрөө

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бид ёстой маш том аюултай дохио шүү дээ. Тэгэхээр би бол энэ надад хариултауд маш дэлгэрэнгүй ирсэн, баярлалаа. Жишээлэхэд Ерөнхий прокурорын газраас бол олон хуудас хангалттай энэ материаллаг ирлээ, би бас ойлголттой боллоо. Хууль зүйн яамнаас бас ирсэн тэгээд би бол тэр хууль өргөн бариад энэ буцаагдсан гэдэг дээр бас эмзэглэж байна л даа. Энийгээ яагаад яаж ийж байгаад батлуулчхаж болоогүй юм бол ингээд хууль буцаагдаад ингэж хугацаа алдаад байна.

Тэр Пүрэвдорж гишүүний хуулийг бас хурдан хэлэлцээд ярилцаар байна. Сая сайдын үгэнд 1 чухал санаа гарлаа. Тэр жижүүрийн шүүхтэй болно гээд. Үүнийг чинь олон жил яриад л байгаа шүү дээ. Хуучин хэрэглэж л байсан практик, тэгээд үүнийгээ ингээд прокурор бол ингээд журам гаргаад жижүүрийн прокуророо томилоод ингээд 1 хүсэл зориг харагдаад байгаа байхгүй юу. Гэтэл ШЕЗ асуудал дээр болохоор ингээд 1 их олон журам гаргадаг хэрнээ энэ дээрээ тийм журмаар шийдэж болохгүй л байсан юм болов уу. Үүнийг асуух гэсэн юм.

2-т, Нямбаатар сайд аа. Би тэр 50% нь гэдэг нарийн тоонуудыг бүгдийг харчихсан. Тэгэхээр 53% нь шүүх үргэлжлүүлж хорино гэхихсэн байна гэдэг чинь цаана нь 40-50% нь ямар ч шаардлагагүй баривчилгаа хийсэн байна гэдгийн нотолгоо байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зүйлийг багасгахын тулд юу хийх ёстой юм бэ? Одоо бас та яг хууль зүйн ямар ямар ажлыг энэ дээр хийж байна вэ гэдгээ надад 1 асуултад хариулаад өгөөч. Би дүгнэлтүүдээ дараа нь хэлье.

Тэр 864 кэйс гээд Хүний Эрхийн комисс надад бас хариулаарай. 864 кэйс дээр та нар яг 60 хувь нь шаардлагагүй баривчилгаа байсан байна гэдгээ гаргачихсан байна. Сайн байна, зөв хийсэн байна, бодитой хийсэн байна. Тэгээд үүнийгээ багасгах тал дээр яг юу хийх юм бэ гэдгийг би сонсмоор байна л даа.

Тэгэхээр асуултаудад хариулсны дараа би бас зүйлүүдээ хэлье.

Дээрээс нь энэ жагсаал, цуглааны хууль гээд өргөн барьсан. Энэ хууль хаана очоод гацчихав. Тэр Цогтгэрэл нарын гишүүд өргөн барьсан энэ хууль орж ирэх гэж байна уу, яах гэж байна? Засагтай хамт ... /минут дуусав/

Б.Энхбаяр: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Яах вэ, ШЕЗ-ийг бас энэ дээр яаж буруутгаж болохгүй л байгаа юм л даа. Бид нар нөгөө жижүүрийн шүүх ажиллах эрх зүйн үндсийг нь хуулиар гаргаж өгье гээд тохирчихсон юм. Тэгээд яг түүн дээр та дэмжээгүй л юм байна лээ. Бас нөгөө дэмжээгүй унагах гишүүдийн юун дотор. ЭХХШТХ-ийг, тийм. Үгүй ээ тэр чинь чуулганаараа орсон шүү дээ, түүн дээр би яг дараа нь дэмжээгүй гишүүдийг харсан чинь та дэмжээгүй л юм байна лээ. Яах вэ, тэр яах вэ.

2-т нь, бид нар тэр Зөрчлийн тухай хууль өргөн барьчихсан, манай энэ Байнгын хороон дээр л байгаад байгаа. Би Пүрэвдорж гишүүнийг ахалчхаасай, энэ ажлын хэсэгт ороод жоохон шахаж ажиллаасай гэж бодоод байгаа юм. Түүн дээр чинь ерөөсөө таны хэлээд байгаа тэр нөгөө Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд байгаа тэр зохицуулалтыг чинь аваад хаячихъя гээд дагасан хууль нь байгаа байхгүй юу. Тэгээд таны өргөн барьсан төсөл 2-ыг нэгтгээд явъя гээд.

Тэгээд та хэд би зүгээр Байнгын хорооныхоо гишүүдэд хэлэхэд бид нар ингээд ХЗБХ, Хууль зүйн яам бол энэ 2020 оноос хойш хамгийн л эрч хүчээрээ л хуулиуд өргөн бариад байгаа юм. Тэгээд гол нь энэ нөгөө хуулиуд маань ирээд энэ Байнгын хороо, Их Хурал дээр ингээд л удаад байгаа байхгүй юу. Тэгээд нөгөө ухна ишигний зовлонг ойлгохгүй гэдэг л зүйл болоод байгаа юм. Тэгээд би

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Одонтуяа гишүүний зүйл дээр хэлэхэд тэр 47.3% чинь яг хойшлуулиггүйгээр баривчлаад байгаа юм. Нөгөө нөгөө 53% нь бол тэрийг бол бид нар гарцаагүй ойлгох ёстой. Үйлдэл дээрээ баригдаж байгаа сэжигтэй хохирогч, энэ намайг хохироосон, энэ намайг хүчиндсэн хүн байна. гэдгийг зааж байгаа тохиолдолд тэрийг таслан сэргийлэх арга хэмжээ авахаас өөр аргагүй болж байгаа юм. 47% дээр яаж бууруулах вэ гэдэг дээр манай яаман дээр төсөл боловсруулаад, зорчих эрхийг хязгаарлах, таслан сэргийлэх арга хэмжээ авъя. Өөрөөр хэлбэл хойшлуулиггүй арга хэмжээнийхээ оронд хойшлуулиггүйгээр баривчлахынхаа оронд нөгөө хүнд гав бугуйвч зүүгээд дуудсан цагт ирнэ шүү гэдэг байдлаар ингээд цаашаа энэ хорионы тоог багасгая л гэж байгаа юм.

Би ШШГЕГ-ын дарга Амарсанаагаас өдөр тутамдаа нөгөө цагдан хоригдож байгаа болон хоригдож байгаа хүмүүсийн тоо мэдээлэл, статистикуудыг авдаг юм. Тэгэхээр манай ерөөсөө дундаж улсын хэмжээнд 1000 гаран 1200 дээр ингээд тогтмол яваад байгаа юм. Тогтмол 1200, тэгээд очоод бид нар орон нутагт энэ тэр ажиллаад үзэхээр аймгуудын цагдан хорих байруудад хоригдож байгаа хүүхдүүдийн дийлэнх нь насанд хүрээгүй хүүхдүүд. Тэр ямар вэ гэхээр хэлэхэд ч хэцүү. Нөгөө хүчингийн хэрэг үйлдсэн, тэгээд хохирогч тухайн хүнийг таньсан, гэрчилсэн, заасан ийм л үйлдлүүд байгаа. Та хэд бас 1 Байнгын хороо хөдөө орон нутгууд энэ тэр тойроод яваарай.

Улаанбаатар хотод цагдан хоригдож байгаа хүмүүсийн тухайд статистик хэргийн өнгөөр нь харахад ихэвчлэн авлига, албан тушаалын хэрэг болон нөгөө мансуурах эм, сэтгэц нөлөөт бодисыг хууль бусаар хадгалсан, тээвэрлэсэн ийм үйлдэл дээр цагдан хоригдож таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа хүмүүс бол түгээмэл байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ юугаа бас яаралтай оруулж ирье. Үүнийг Байнгын

хороо дэмжээд өгвөл энэ ... /минут дуусав/

Б.Энхбаяр: ХЭҮК-ын гишүүн Энхболд нэмж хариулъя. 7 номерын микрофон.

Б.Энхболд: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Тэр сүүлийн 3 жилийн байдлаар шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдаад суллагдсан нийт хүний тоо 1135 байгаа. ХЭҮК үүнээс 864 буюу 76 хувьд нь материал дээр нь дүн шинжилгээ бол хийсэн. Энэ 864 кэйсээс аваад үзэхэд нийтдээ 631 нь буюу 73% нь шүүхийн хяналтад ороогүй байна гэдэг ийм дүгнэлтийг гаргасан. Үүнээс 529-ийг прокурорын байгууллага, 102-ыг ШШГБ-ын албан тушаалтан бол 48 цагийн хугацаа дууссан гэдэг үндэслэлээр суллаж гаргасан байгаа юм. Тэгэхээр эндээс юу харагдаж байна вэ гэхээр тухайн хүнийг 48 цагийн хугацаанд баривчлах энэ хооронд анхны хуульд заасан 4 үндэслэл байсан уу, үгүй юу гэдэг бол бас анхаарал татаж байгаа учраас үүнийгээ цааш нь шүүхийн хяналтад бүрэн оруулах ёстой гэдэг ийм байр илэрхийлж байгаа.

Үүнийг даван туулах ямар арга хэмжээ байна вэ гэхээр түрүүн сайдын хэлдэг тэр зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний оронд хэрэглэх, мөн энэ шүүхэд мэдэгдэлгүйгээр сулласан тохиолдолд үүнийгээ нөхөж мэдэгддэг тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай юм байна лээ. Тэгэхээр шүүх огт үүнийг мэдэхгүй өнгөрч байгаа нь бол харамсалтай байгаа.

3 дугаарт нь, энэ хуульд заасан хуулийн хэрэгжилтийг 1 мөр ойлгож, зөв хэрэгжүүлэх энэ сургалт, мэдлэг хандлагыг өөрчлөх ийм шаардлага байна гэж дүгнэж байгаа.

Б.Энхбаяр: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХЗДХ-ийн сайдаас ирүүлсэн асуултын хариутай холбогдуулан УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга Одонтуяа дарга уг хэлнэ.

С.Одонтуяа: Баярлалаа. Тэгэхээр би бас ХЗБХ-нд харьяалагддаггүй болохоор зарим орж ирж байгаа хуулийн талаар бас мэдээлэл бага байж болно. Гэхдээ би зүгээр нийт хандлагыг яриад байгаа юм. Өнөөдөр Монгол Улс 3.3 сая хүнтэй, 1.2 сая нь хүүхэд, 328000 нь ахмад, 130000 хөгжлийн бэрхшээлтэй, гадаадад 200000, 530000 гэртэй хүүхэд таарч байна гэвэл цаана нь хэдхэн хүн үлдэж байгаа байхгүй юу. Энэ хэдхэн хүнийг чинь 1 аятайхан улс 1 бодлогоор чиглүүлээд аваад явж болно доо. Гэтэл энэ хэдхэн хүнийг чинь юм л бол саатуулаад л, юм л бол баривчлаад л, юм л бол цагдан хориод байдаг энэ би хандлагыг нь ярьж байгаа юм. Түүнээс биш мэдээж түүн дотор би зөв баривчилсан, тэр шүүхээр шийдвэрүүд гарч байгаа, үүнийг бол би үгүйсгэхгүй. Гэхдээ зүгээр би нийт хандлагыг нь яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ямар асуудал яримаар байна гэхээр тэр туршлагыг тэр ХЭҮК-ын Энхболд даргын тэр ярилцлагыг би бас анхааралтай унисан. ХБНГУ, Япон, Солонгос энэ улсуудад яадаг вэ гэхээр энэ тодорхой хязгаарлалтуудыг нь зааж өгсөн байгаа юм. Хэрвээ сэжигтэн оршин суугаа хаяг нь тодорхой, оргон зайлах бодит үндэслэл байхгүй, ажил хөдөлмөр эрхэлдэг байвал аль болох ажлын бус цагаар баривчлахгүй байх, тэдгээрийн гэр бүлийн хүмүүс хамаарал бүхий хүмүүс сэтгэл зүйн дарамт үзүүлэхгүйгээр мөрдөн шалгах ажиллагааг явуулна гэж. Тэгэхээр бид нар энэ туршиллагуудыг аль болох энэ хэрэглэх хэрэгтэй. Нөгөө хуучны юм чинь арга хуучирчхаад байна шүү дээ. Юм л бол 1 шоронд хорьж байгаад л ингээд хүнийг 1 залхаан цээрлүүлж байгаад л 1 хэрэг хүлээлгэх. Энэ юм чинь бол хоцрогдсон. Тийм учраас энэ аргуудыг нэгдүгээрт хэрэглэх хэрэгтэй.

Дээрээс нь тэр 40% бол шаардлагагүй баривчилгаа байсан байна гэдгийг ХЭҮК гаргаад өгчихсөн Хууль зүйн яамны өөрийнх нь тайланд ирсэн. Тийм учраас одоо энэ 40%-ийг өшөө багасгах ёстой. Тэгээд би бол ХЭҮК-ыг бол ер нь хараат бус сайн ажиллаж байна л гэж дүгнэх гээд байгаа. Тэгээд цаашид энэ хуулиудыг маш яаралтай оруулж ирэх хэрэгтэй. Үгүй ээ, тэгээд л 1 цөөхөн хэдэн хүнээ уг хэлээд үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө тэгээд л үгүй ээ 1 Монгол Улс даяараа л 1 юм болох юм. Энэ чинь нийгэмдээ аягүй муухай сөрөг үр дагавартай байгаа байхгүй юу. Тэгээд л гарч ирээд л шүүхэд нөлөөлөх гээд л баахан ерөөсөө сүүлийн үед сошиал дээр гарч байгаа юмнууд л шүүнэ, цагдан хорино. Ийм зүйлийг бол бид нар нийгэм амьсгалмааргүй байна. Тийм учраас энэ хүмүүс чинь халгаад ерөөсөө гадагшаа явъя, ерөөсөө Монгол Улс чинь ингээд л юм л бол шүүдэг юм байна, баривчилдаг юм байна, цагдан хорьдог юм байна гэсэн ийм ойлголт яваад байна.

Тэгэхээр энэ нийт хандлага, бид нар хандлагаа л өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна. Тэгээд ХЗБХ-ны даргад бас хандаж хэлэхэд энэ хууль зүйд хуулиудыг нь яаралтай оруулж ирээд батлуулаадхаач. Хүний эрхийг 1 хоногоор ч гэсэн бид нар зөрчиж болохгүй. Гэтэл нийт баривчилгааны 40% нь шаардлагагүй баривчилчихсан байна. Одоо алдаагаа засъя. Нийт баривчлаад хэдэн сараар, жилээр хорьчихсон хүний, 5 хүний 1 нь л шүүхээр ял аваад, 4 нь буруугүй гээд гарчихсан байна шүү дээ. Энэ чинь асар өндөр тоо шүү дээ. Тэгээд тэр хүмүүсээс буцаад ямар нэгэн сэтгэл санаа нь тэр айл зүгээр тэр чигээрээ сүйрчихсэн л байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ чиглэлээр би нийт хандлагыг ярьж байгаа юм. Түүнээс биш 1 нарийн бүх зүйлүүд нюансыг бол би бол ойлгож байна.

Тэгээд Ерөнхий прокурор бол бас яг хуулийнхаа хэмжээнд өөрсдөө ажиллаад

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа гэдэг бүүр хүсэл зоригийг бол харсан. Гэхдээ прокурор тэр шаардлагагүй 40%-ийн баривчилгааг багасгах тал дээр бас ажиллаач ээ гэдгийг би бас хэлмээр байна.

Тэр бусад орны энэ туршлагауд байж байна. Тэгээд Хууль зүйн яам бол тэр хуулиудаа оруулж ир. Тэгээд шаардлагатай гэвэл яг энэ хүний эрхийн чиглэлээр ажиллаад байгаа бид нартай бас уулзаж, энэ асуудлуудаа бас тайлбарлах хэрэгтэй. Бид нар энэ хуулийг чинь шаардлагатай зүйлүүдийг нь дэмжээд явахад бэлэн байна.

Энэ хүний эрхийн асуудлаар Монгол Улс ухраад байж л болмооргүй байна. Ухраад байж. Одоо тэр хүний эрхийн хороон дээр илтгэл хэлэлцэхэд 98% нь Монгол Улс шүүхийн шийдвэргүй баривчилдаг гээд л шивишиг болмооргүй байна шүү дээ. Тэр чинь дэлхийн улс орнууд гайхна биз дээ. Энэ чинь Монгол. Тэгэхээр чинь яах юм бэ? Энэ бүх энэ хөрөнгө оруулалт татагдана, залуучууд чинь гадагшаа дүрвэх нь ойлгомжтой шүү дээ. Тэгэхээр бид нар энэ асуудал дээр 1 юмыг 1 Монголчлоод байхгүйгээр одоо энэ 50, 60-аад оныхоо энэ юунаас салмаар байна шүү дээ. Хуучин зүйлээс.

Энэ хүний эрх гэдэг чинь 1 хоногоор ч гэсэн зөрчигдөхгүй байх ёстой гэдгийг л ойлгомоор байна. Би маш олон тэр 461-д сууж байгаад гарчихсан байсан хүнээс асуусан шүү дээ. Хэдэн сараар мэдүүлэг авдаг вэ? Хэдэн сараар ... /минут дуусав/

Б.Энхбаяр: УИХ-ын гишүүн Одонтуяагаас ХЗДХ-ийн сайд Нямбаатарт тавьсан асуултын хариултыг сонслоо.

13.23 цаг

ХЗБХ-ны өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ